

БАТЛАВ.

БОАЖЯ-НЫ ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧИН, БАЙГАЛИЙН НӨӨЦИЙН УДИРДЛАГЫН
ГАЗРЫН ДАРГА...../Ц.Уранчимэг/

ЗӨВШӨӨРЧ, ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮҮРЭГ ХҮЛЭЭСЭН:

“КАПКОРП МОНГОЛИА” ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИГАЛ...../А.Гэрэлт-Од/



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН НУТАГТ ОРШИХ ГАЗРЫН ТОСНЫ
БҮТЭЭГДЭХҮҮН ХУВААХ ГЭРЭЭТ “ОНГИ-V” ТАЛБАЙН БАРУУНБАЯН-
УЛААН, ГУЧИН-УС СУМЫН НУТАГТ “З ХЭМЖЭЭСТ ЧИЧИРХИЙЛЛИЙН
СУДАЛГАА, ГАЗРЫН ТОСНЫ ХАЙГУУЛЫН ЦООНОГ ӨРӨМДӨХ”
ТӨСЛИЙН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨ**

/Газрын тосны хайгуулын тусгай зөвшөөрлийн дугаар: 736/
/Регистрийн дугаар: 5077982/

Хянасан:

БОАЖЯ-НЫ ХБОБНГ-ЫН АХЛАХ ШИНЖЭЭЧ...../Ц.Жаргалнэмэх/

Боловсруулсан:

“Капкорп Монголиа” ХХК-ний ХАБЭАБО-НЫ
хэлтсийн дарга/Гэри Ниэл/

2023 он

АГУУЛГА

НЭГ. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА.....	5
1.1. Төслийн товч танилцуулга.....	5
1.2. 2023 онд хийгдэх ажлын танилцуулга.....	6
1.3. Цооногийн өрөмдлөг.....	9
1.4. Цооногийн туршилт.....	13
1.5. Шингэн хагалбар.....	15
1.6.1. Тэсрэх бодисын хэрэглээ.....	17
1.6.2. Цацраг үүсгүүрийн ашиглалт.....	17
1.6. Эрчим хүчний хангамж.....	17
1.7. Ажилчдын тоо, ажиллах горим.....	18
1.8. Усны эх үүсвэр ба ус хэрэглээ.....	18
1.9. Химийн бодисын хэрэглээ.....	21
1.10. Өрөмдөх цооногуудад хийх шингэн хагалбарын ажилд хэрэглэх химийн бодисын хэрэглээ.....	22
ХОЁР. ТӨСЛИЙН ТАЛБАЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ ТӨЛӨВ БАЙДАЛ.....	24
2.1. Физик газарзүйн нөхцөл.....	24
2.2. Уур амьсгалын нөхцөл.....	25
2.3. Хөрсөн бүрхэвч.....	26
2.4. Гадаргын ус.....	26
2.5. Амьтны аймаг.....	27
2.6. Ургамлан нөмрөг.....	27
2.7. Геологийн тогтоц.....	28
3.1. Төслийн гол болон болзошгүй нөлөөлөл.....	29
3.2.Төслийн нөлөөллийн хэлбэр, эрчим, үргэлжлэх хугацаа.....	29
3.3.Төслийн байршил, шийдэл, төлөвлөлтөөс үүсэх нөлөөлөл.....	32
ДӨРӨВ. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	33
4.1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө.....	35
4.2. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө.....	42
4.3. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө.....	44
4.4. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө.....	44
4.5. Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө.....	44
4.6. Осол эрсдлийн менежментийн төлөвлөгөө.....	44
4.7. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө.....	46
4.8. ХИМИЙН БОДИСЫН ЭРСДЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	49
4.9. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр.....	53
4.10. Удирдлага зохион байгуулалтын арга хэмжээний төлөвлөгөө.....	55
4.11.БОМТ-ний хэрэгжилтийг нөлөөлөлд өртөх оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь.....	56

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. 1. Бүтээгдэхүүн хуваах гэрээт Онги V талбайн байршлын зураг	5
Зураг 1. 2. Онги-V талбайн засаг захиргааны зураг	6
Зураг 1. 3. Өрмийн цамхгийн схем	10
Зураг 1. 4. Хаягдлын сангийн план зураг	12
Зураг 1. 5. Өрөмдлөгийн талбайн ерөнхий план	13
Зураг 1. 7. Шингэн хагалбар хийх ажлын бүдүүвч	16
Зураг 2. 1. Өрөмдлөг хийх талбайн орчны харагдах байдал	24
Зураг 2. 2. Монгол орны физик-газарзүйн зураг	25
Зураг 2. 3. Монгол орны хөрсөн бүрхэвчийн зураг	26
Зураг 2. 4. Монгол орны гидрогеологийн зураг	27

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. 1. Туршилт, үйлчилгээнд ашиглах техник, тоног төхөөрөмж	15
Хүснэгт 1. 2. Шингэн хагалбарт ашиглах тоног төхөөрөмж	16
Хүснэгт 1. 3. Ажлын үргэлжлэх хугацаа болон ажиллах хүчний нэгдсэн мэдээлэл	18
Хүснэгт 1. 4. Газрын тосны эрэл хайгуул, олборлолтын өрөмдлөгийн ус зарцуулалтын норм (Өрөмдлөг хийх хоног тутамд 1 цооногт)	18
Хүснэгт 1. 5. Технологийн хэрэгцээнд ашиглах усны хэмжээ, тн	18
Хүснэгт 1. 6. Унд ахуйн хэрэгцээнд ашиглах ус	20
Хүснэгт 1. 7. Нийт ус хэрэглээний дүн	20
Хүснэгт 1. 8. Цооног өрөмдлөгийн явцад ашиглагдах химийн бодисуудын нэрс	21
Хүснэгт 1. 9. Шингэн хагалбарын ажилд хэрэглэх химийн бодис	23
Хүснэгт 1. 10. Цооногуудад хийх туршилтын ажилд хэрэглэх химийн бодисын хэрэглээ	23
Хүснэгт 3. 1. Нөлөөллийн хэлбэр, үргэлжлэх хугацаа, эрчимшил	30
Хүснэгт 4. 1. Агаарын чанарт нөлөөлөх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	35
Хүснэгт 4. 2. Гадаргын ба газрын доорхи усны нөөцөд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	36
Хүснэгт 4. 3. Хөрсөн бүрхэвчид үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	39
Хүснэгт 4. 4. Ургамлан нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	40
Хүснэгт 4. 5. Амьтны аймагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	41
Хүснэгт 4. 6. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	42
Хүснэгт 4. 7. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	44
Хүснэгт 4. 8. Осол эрсдлийн менежментийн төлөвлөгөө	44
Хүснэгт 4. 9. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	46


Хүснэгт 4. 10. Химийн бодисын эрсдлийн менежментийн төлөвлөгөө	49
Хүснэгт 4. 11. “Химийн бодисын эрсдлийн менежмент”-ийн төлөвлөгөө “Цацрагийн үүсгүүр” ..	51
Хүснэгт 4. 12. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	53
Хүснэгт 4. 13. БОМТ -ний хэрэгжилтийг нөлөөлөлд өртөх оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь	56
Хүснэгт 4. 14. БОМТ -ний зардлын хураангуй	58

НЭГ. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1.1. Төслийн товч танилцуулга

“Сентрал Азиан Петролеум Корпорэйшн Лимитед” компани нь 2009 оны 7 дугаар сард Монгол Улсын Засгийн газартай газрын тосны хайгуулын Онги V талбайд “Бүтээгдэхүүн хуваах гэрээ” /БХГ/ байгуулан газрын тосны хайгуул, судалгааны ажлыг 14 дэх жилдээ явуулж байна.

“Капкорп Монголиа” ХХК нь “Сентрал Азиан Петролеум Корпорэйшн Лимитед” компанийн охин компани бөгөөд эх компанийн өмнөөс Монгол дахь үйл ажиллагааг хариуцан ажилладаг. Газрын тосны хайгуулын БХГ-т Онги-V талбай нь Монгол орны баруун урд хэсэгт, Улаанбаатар хотоос баруун урагш 450 орчим километр орших бөгөөд нийт талбайн хэмжээ 32, 030 км² байснаас БХГ-ний 7.1 – ийн а/ заалт болон “Газрын тосны тухай хууль”-ийг хэрэгжүүлэх журмын 14.1 заалтуудыг үндэслэн 2011 оны 10 дугаар сарын 31-ны өдөр хайгуулын үйл ажиллагаа явуулахгүй талбайн хэсгийг буцааж өгснөөр нийт хайгуулын талбай 21, 100 км² болсон ба хамгийн сүүлд 2020 онд хайгуулын талбайг хэсэгчлэн буцааснаар шинэчлэгдсэн талбайн хэмжээ нийт 7936,9 км² болсон байна. Хайгуулын талбайн байршлыг Зураг 1.1-д харуулав.




Цэгийн дугаар	Солбицол, WGS 84	
	Уртраг	Өргөрөг
1	101° 30' 1.775" E	45° 24' 28.800" N
2	102° 27' 8.197" E	45° 24' 28.800" N
3	102° 27' 8.197" E	44° 52' 12.000" N
4	101° 30' 1.775" E	44° 52' 12.000" N

Цэгийн дугаар	Солбицол, WGS 84	
	Уртраг	Өргөрөг
5	102° 57' 48.190" E	45° 43' 35.717" N
6	102° 57' 48.190" E	45° 9' 43.200" N
7	102° 39' 59.000" E	44° 40' 0.000" N
8	102° 39' 59.000" E	45° 0' 0.000" N

Зураг 1. 1. Бүтээгдэхүүн хуваах гэрээт Онги V талбайн байршлын зураг

Онги-V талбай нь засаг захиргааны нэгжийн хувьд Өвөрхангай аймгийн Баруунбаян-Улаан, Гучин-ус, Богд, Баянгол, Төгрөг, Нарийнтээл, Хайрхандулаан сумдын нутаг дэвсгэр хамрагддаг. Онги-V талбай орших нутаг дэвсгэрийн засаг захиргааны нэгжийг Зураг 1.2-т үзүүлэв.



Зураг 1. 2. Онги-V талбайн засаг захиргааны зураг

1.2. 2023 онд хийгдэх ажлын танилцуулга

Бүтээгдэхүүн хуваах гэрээ /БХГ/ -т газрын тосны хайгуулын Онги-V талбайд 2023 онд /гэрээт 14 дэх жил/ газрын тосны хайгуулын ажлын хүрээнд Өвөрхангай аймгийн Баруунбаян-Улаан, Гучин-Ус сумдын нутагт 150 км² талбайг хамарсан 3 хэмжээст чичирхийллийн хайгуул судалгааны ажил, болон Баруунбаян-Улаан сумын нутагт хайгуулын тулгуур 2 цооногийг өрөмдөнө. Өрөмдлөгийн үр дүнгээс хамаарч, өөрөөр хэлбэл газрын тостой эсвэл газрын тостой байх шинж тэмдэг илэрвэл тус цооногуудад цооногийн туршилт, шингэн хагалбар зэрэг өрөмдлөгийн дараах ажлууд хийгдэнэ.

№	Үндсэн үзүүлэлтүүд	Тайлбар
1	Төслийн нэр	Газрын тосны хайгуулын 3 хэмжээст чичирхийллийн судалгаа, хайгуулын тулгуур цооног өрөмдөх төсөл
2	БОНЕУ-ийн дугаар	2019/Т093
3	Төсөл хэрэгжүүлэгч	“Капкорп Монголиа” ХХК
4	Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг	Монгол улс Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Энхтайваны өргөн чөлөө 17, 1-р хороо, Блю Скай цамхаг, 508 тоот

5.	Хүчинтэй хууль эрхзүйн баримт бичгүүдийн жагсаалт	<ol style="list-style-type: none"> 1. Аж ахуйн нэгжийн гэрчилгээний Улсын бүртгэлийн дугаар 9019014069, Регистрийн дугаар 5077982; 2. “Капкорп Монголиа” ХХК-ний Газрын тос хайх тусгай зөвшөөрөл 3. Монгол улсын Засгийн газрын 2006 оны 7-р сарын 19-ний өдрийн “Бүтээгдэхүүн хуваах гэрээ батлах тухай” 170 дугаар тогтоол 4. Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас 2019 оны 05-р сарын 29-ний өдөр ирүүлсэн дугаар 2019/Т-093 байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээний дүгнэлт 5. 2021 оны 12-р сард батлагдсан Онги-V талбайд хайгуулын 2 цооног өрөмдөх төслийн Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний тайлан 6. Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас 2022 оны 08-р сарын 23-ний өдөр ирүүлсэн дугаар 2022/Т-087 байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээний дүгнэлт 7. 2023 оны 1-р сард батлагдсан Онги-V талбайд хайгуулын 2 цооног өрөмдөх төслийн Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний тодотгол (3 хэмжээст чичирхийллийн судалгаа) 8. Өвөрхангай аймгийн Баруунбаян-Улаан сумын Өлзийт хошуу 3-р багийн ИНХ-ын 2021 оны 12-р сарын 06-ны өдрийн 2 дугаар тэмдэглэл 9. Өвөрхангай аймгийн Гучин-Ус сумын 2, 3-р багийн 2022 оны 9-р сарын 29-ний өдрийн иргэдийн нийтийн хурлын тэмдэглэл 10. Өвөрхангай аймгийн Баруунбаян-Улаан сумын 3-р багийн 2022 оны 9-р сарын 20-ны иргэдийн нийтийн хурлын тэмдэглэл,
----	---	---

1.3.3 хэмжээст чичирхийллийн судалгаа

Газрын тос агуулж буй газрын гүний геологийн бүтэц, тогтцыг тодорхойлох хайгуулын чухал аргуудын нэг бол 2 болон 3 хэмжээст чичирхийллийн судалгааны ажил ба уг судалгааг тэсэлгээний болон вибро-сейсмийн гэсэн 2 аргачлалаар хийж гүйцэтгэдэг.


“Капкорп Монголиа” ХХК нь 2023 онд хайгуулын ажлын хүрээнд нийт 150 км² хүртэлх талбайд 3 хэмжээст чичирхийллийн судалгааны хээрийн хэмжилтийг вибро-сейсмийн аргачлалаар хийхээр төлөвлөж байна. Вибро-сейсмийн аргачлал нь тэсэлгээний цооног өрөмдөж, газарт олон тооны нүх үүсгэдэггүй тул байгаль орчинд ээлтэй технологи юм.

Гурван хэмжээст (3D) чичирхийллийн судалгааны ажлыг гүйцэтгэх техник, тоног төхөөрөмж ба хэмжилтийн параметруудийг Зураг 1.2-1.5 болон Хүснэгт 1.3, хээрийн ангийн бүдүүвчийг Зураг 1.6-д тус тус үзүүлэв.

Хүснэгт 1. 1. Техник, тоног төхөөрөмж

№	Төрөл	Зориулалт	Тоо
Хайгуулын багийн удирдлага ба тээвэрлэлт			
1	Хьюндай ачааны машин	Тээврийн машин/Монгол/	1
2	Жийп	ХХАБА ба Чанарын хяналт баг	1
3	Жийп	Орон нутгийн харилцаа/Монгол/	1
4	Бага оврын автобус	Мах тээвэр	2
5	Жийп	Төслийн менежер	1

6	Жийп	Захиалагч	2
7	Шатахууны машин	Шатахуун хадгалах/35тн/	1
Хэмжилтийн баг			
8	Trimble R7 R8	RTK	8+2
9	Бага оврын автобус	Хүн тээвэр	2
10	Жийп	Хүн тээвэр	1
Вибраторын баг			
11	BV620-LF	Вибратор	5
12	Бага оврын автобус	Жолооч хүргэх	1
13	Шатахуун машин	Вибраторуудад шатахуун түгээх	2
Бичиглэлийн баг			
14	Sercel 428L	Бичиглэлийн систем	1
15	FLDV	Хайрцаг	6000
16	LUL	Тэжээлийн станц	
17	30DX-10	Геофон	6200
18	SMT - 200	Геофон тестлэгч	2
19	Жийп	Төслийн менежер	1
20	Linkstar	Хиймэл дагуулын хүлээн авагч	2
21	Dongfeng (EQ2162N)	Шугам шалгагч	2
22	Бага оврын автобус	Шугамын баг	12
23	Пик-ап	Шугам шалгагч	8
24	Пик-Ап	Цэвэрлэгээний баг	1
25	Пик-Ап	Засварын баг	1
26	Жийп	Хамгаалалт	2



Зураг 1. 3. Чичирхийллийн судалгааны ажлын схем




Зураг 1. 4. Bv620-lf төрлийн вибратор



Зураг 1. 5. Вибраторийн машин уян харимхай долгион үүсгэж буй нь



Зураг 1. 6. Вибраторийн машин уян харимхай долгион үүсгэсний дараа



Зураг 1. 7. 3 хэмжээт чичирхийллийн судалгааны хайгуулын хээрийн ангийн бүдүүвч

Онги-V талбайд 3 хэмжээт чичирхийллийн судалгааны ажлыг гүйцэтгэхэд 250 ажилтан байрлуулах 64 гэр сууц, эмнэлгийн тусламж үзүүлэх байр, оффис бүхий хээрийн анги байгуулах бөгөөд нийт 4 га талбайг хамарна. (Зураг 1.6)

1.4. Цооногийн өрөмдлөг


Геологи, геофизикийн урьдчилсан судалгааны үр дүнд тогтоосон газрын тос агуулж болох бүтцийг үнэлэх, нарийвчилсан геофизикийн судалгаа хийх, газрын тос агуулж буй давхаргын петрофизик шинж чанар, агуулж буй шингэний физик, химийн шинж чанар, давхаргын тос өгөлтийг тодорхойлох, улмаар газрын тосыг олборлох зорилгоор цооног өрөмдлөгийн ажлыг гүйцэтгэдэг.

Өрөмдлөгийн үед өрмийн үзүүрийн багаж буюу цүүцээр бутлагдсан чулуулгийн үртсийг цооногоос тээвэрлэн гаргах, цооногийн мөргөцгийг цэвэрлэх үзүүрийн багажийг хөргөх зорилгоор угаалгын шингэнийг ашигладаг. Хурдас чулуулгийн уул-геологийн нөхцөлөөс хамаарч цооногийн өрөмдлөгт хэрэглэх угаалгын шингэнд тавигдах шаардлага янз бүр байдаг. Монгол орны нөхцөлд усан суурьтай угаалгын шингэнийг хэрэглэж байна. Угаалгын шингэний үндсэн түүхий эдэд байгалийн гаралтай бентонит, барит ба лигнит шаврууд, хлорт калийн давс, техникийн шүү болон бусад полимер хольцууд болох хор хөнөөл багатай байгалийн гаралтай бүтээгдэхүүнүүдийг ашигладаг.

Цооногийн өрөмдлөг дараах ерөнхий дарааллын дагуу явагддаг. Үүнд:

- Өрөмдлөгийн талбай бэлтгэх
- Өрмийн цамхаг, хээрийн ангийн тээвэрлэлт
- Өрмийн цамхаг угсрах, бэлтгэл ажлууд (Угаалгын шингэн бэлтгэх, өрмийн шингэн хаягдлын сан байгуулах г.м)

- Цооногийн өрөмдлөг (Өрөмдлөгийн явцад шаврын бичиглэл давхар хийнэ)
- Цооногийн ханыг нурахаас урьдчилан сэргийлж бэхэлгээ хийх (бэхэлгээний яндан суурилуулах, цементлэх)
- Цооногт каротажийн судалгаа хийх



Зураг 1. 8. Өрмийн цамхгийн схем

Цооногийн өрөмдлөгт ашиглах техник, тоног төхөөрөмжийг Хүснэгт 1.4-д харуулав.


Хүснэгт 1. 1. Цооног өрөмдөхөд ашиглах багаж тоног, төхөөрөмж

Тоног төхөөрөмж	Үйлдвэрлэгч	Техникийн үзүүлэлт
Т 130 Өрөмдлөгийн цамхаг	Schramm	760HP /130,000 lbs pull back /8,884ft-lbs torque
Яндан холбогч тавцан	Alpine Engineering	Range 3 capable Rod and Casing handler
Өрөмдлөгийн үзүүлэлтүүдийг хэмжигч мэдээллэх төхөөрөмж	Rapid logger	Cloud based Live logging of well and rig parameters
GD THE5 шаврын насос 1	Gardner Denver	260HP /462 GPM max discharge / 2944 PSI max pressure
GD THE5 шаврын насос 2	Gardner Denver	260HP /462 GPM max discharge / 2944 PSI max pressure
GD TGE5 шаврын насос 3	Gardner Denver	260HP /462 GPM max discharge / 2944 PSI max pressure
FMC 535 насос	FMC Bean	25HP /45 GPM max discharge / 1000 PSI max pressure
Насос	Sand Guzzler	2 X SG T11 500GPM
Сорох насос	G&N	6 X 8 Centrifugal charge pump with pulsation dampener
Шаврын цэвэрлэгээний төхөөрөмж	G&N	800 GPM / shale shaker / desander /desilter
Шаврын сав	G&N	157 bbl /25m3 total capacity partitioned for mixing & settling
Шаврын сав	MDM Engineering	205 bbl. / agitators / charged suction manifold with dampener
Шаврын лаборатори	Imdex	API grade field lab in 20Ft container
Цахилгаан үүсгүүр 1	Victory Power	VP V220C 275kva 380/220 50Hz
Цахилгаан үүсгүүр 2	Atlas Copco	QES 100kva 85 kw G3


Цахилгаан үүсгүүр 3 гэрэлтүүлгийн	Allight	10kva
Цахилгаан үүсгүүр 4 гэрэлтүүлгийн	Allight	10kva
Гидро насос	MDM Engineering	260HP / 3000 PSI max pressure
Ачааны машин 8X8 Hiab	Mercedes	flat bed 20Ft ISO container ready
Усны машин	Mercedes	Prime mover with 30,000 литр багтаамжтай цистерн
Шатхууны машин	Isuzu	15,000 л багтаамжтай, тоолууртай машин
Яндан өргөгч машин	Genie	74HP/ 4.5T / 17.3m max
Авто мшин	Toyota	Landcruiser 79 and Hilux
Оргилолтоос хамгаалах төхөөрөмж		
7 1/16 оргилолтоос хамгаалах төхөөрөмж	Etang Equipment	Annular BOP 7-1/16” up to 3000 psi top studded , bottom flange
7 1/16 оргилолтоос хамгаалах төхөөрөмж	Etang Equipment	Double ram BOP 7 1/16” x 3000psi 3-1/2” Pipe Ram / Blind Ram
Оргилолтоос хамгаалах төхөөрөмжийн удирдлагын төхөөрөмж	Etang Equipment	Model FK125-4 / 3 station / 40 gallon accumulator / алсын удирдлагатай
Урсгал, даралт хуваарилах төхөөрөмж	Etang Equipment	5000psi /3" twin variable manual choke valves
Урсгал, даралт хуваарилах шугам	Etang Equipment	5000psi /3" / 20Ft with API flanged ends
Хий ялгагч төхөөрөмж	GN Solids	JYQ-800-1 / 145 psi working pressure / 250m ³ Hr
FSOV / IBOP	Etang Equipment	2 X 5000 psi FSOV 1 X 5000 psi IBOP
Туршилтын насос	Etang Equipment	DTA 2XP pneumatic pump and 1000lt pod rated 10000 psi
Өрөмдлөгийн яндан, багаж		
Өрөмдлөгийн яндан 3 1/2" IF EX Upset	Tianhe	NC38 /13.3ppf/G105/ Range 1 / 180 ширхэг / 3600Ft / 1000 метр
Өрөмдлөгийн яндан 3 1/2" IF Int/Ex upset	Driconeq	NC38 /17.8ppf/S135/ Range 1 / 180 ширхэг / 3600Ft / 1000 метр
Хүнд жинтэй өрөмдлөгийн яндан 3 1/2" IF HWDP	Tianhe	NC38 /24ppf/ Range 1 /5 ширхэг / 100Ft / 30 метр
4 3/4" голчтой хүндрүүлэгч яндан	Tianhe	NC 38 /50ppf/ 10Ft / 2 ширхэг / 20Ft / 6 метр
4 3/4" голчтой хүндрүүлэгч яндан	Tianhe	NC 38 /50ppf/ R1 / 16 ширхэг / 320Ft / 97 метр
6" голчтой хүндрүүлэгч яндан	Tianhe	4" IF / 79 ppf/ 10Ft / 2 ширхэг / 20Ft / 6 метр
6" голчтой хүндрүүлэгч яндан	Tianhe	4" IF / 79 ppf/ R1 / 10 ширхэг / 200Ft / 60 метр
8" голчтой хүндрүүлэгч яндан	Tianhe	6 5/8 Reg / 150 ppf/ 10Ft / 2 ширхэг / 20Ft / 6 метр
8" голчтой хүндрүүлэгч яндан	Tianhe	6 5/8 Reg / 150 ppf/ R1 / 2 ширхэг / 200Ft / 12 метр
4 3/4" голчтой тогтворжуулагч	Tianhe	NC38 box X 3 1/2 Reg Box/ 4 3/4 body 6 1/4” blades / 1 ширхэг
4 3/4" голчтой тогтворжуулагч	Tianhe	NC38 Pin X NC38 Box/ 4 3/4 body 6 1/4 blades / 2 ширхэг
6" голчтой тогтворжуулагч	Tianhe	4 1/2 IF box X 4 1/2 Reg Box/ 6" body 8" 3/4 blades/ 1 ширхэг
6" голчтой тогтворжуулагч	Tianhe	4 1/2 IF box X 4 1/2 IF Box/ 6" body 8" 3/4 blades/ 2 ширхэг
8" голчтой тогтворжуулагч	Tianhe	6 5/8 Reg box X 6 5/8 Reg Pin/ 8" body 12" 1/4 blades/ 1рce
Бэхэлгээний яндан , цементацийн тоног төхөөрөмжүүд		
Цемент шахагч толгой	Tianhe	7 inch LTC Single Plug
Цементацийн төхөөрөмж	MDM Engineering	150 bbl NOV pcv pump 300 psi /GD TGE pump 2944 psi/ jet mixer
Бэхэлгээний яндан өргөгч холбоос	MDM Engineering	7 inch LTC X 3 1/2 IF pin

Өрмийн шингэн хаягдлын сан: Цооног өрөмдөх үйл ажиллагааны явцад гарах өрмийн шингэн хаягдлын санг орон нутгаас зөвшөөрсөн газарт байгуулж ашиглах ба түүний эзэлхүүнийг хаягдал шингэний хэмжээтэй уялдуулан тооцно. Хийцийн хувьд бетонон доторлогоо хийхийг хориглох ба хөрсөнд шингэн нэвчихээс сэргийлж, сангийн ёроол болон ханыг геомембран хальсаар битүү доторлож хүн, мал, хээрийн зэрлэг амьтан, шувуу, машин техник унахаас сэргийлсэн бат бэх хашаа болон торон хамгаалалттай хийнэ. Уг санд хуримтлагдах өрмийн шингэний усыг ууршуулж дараа нь техникийн болон биологийн нөхөн сэргээлтийг MNS 6200:2010 стандартын дагуу хийж орон нутагт актаар хүлээлгэн өгнө.

2023 онд өрөмдлөгийн талбайн техникийн нөхөн сэргээлтийг тухайн цооногт хийгдэх бүх туршилт судалгаа, эрчимжүүлэлтийн ажлууд хийгдэж дууссаны дараа гүйцэтгэнэ. Үүнд өрмийн шингэн хаягдлын сан, бохирын септик танк байршуулсан нүх, талхлагдсан талбай зэргийг нөхөн сэргээх ажлууд багтана. Өрөмдлөгийн талбайн биологийн нөхөн сэргээлтийн хувьд мөн газрын гадарга дээрх ажил бүрэн хийгдэж, түр хугацаанд ашигласан тоног төхөөрөмжүүдийг нүүлгэн шилжүүлсний дараа ургамал ургах улирлыг харгалзан үзэж мэргэжлийн байгууллагаар хийж гүйцэтгүүлнэ.



Зураг 1. 9. Хаягдлын сангийн план зураг



Зураг 1. 10. Өрөмдлөгийн талбайн ерөнхий план

1.5. Цооногийн туршилт

Цооногийн өрөмдлөгийн ажил дууссаны дараа, шаардлагатай цооногуудад туршилтын ажил хийдэг ба энэ нь, тухайн цооногийн мөргөцгийн даралт, температур, олборлох шингэний ундарга, тосны шинж чанар, хураагуурын зарим үзүүлэлтүүдийг (хураагуурын анхны даралт, нэвчүүлэмж, тостой үеийн зузаан г.м) тодорхойлох зорилгоор хийдэг ажил. Уг туршилтын ажлыг эхлэхийн өмнө перфорацийн буу ашиглан, перфораци буюу бэхэлгээний янданд тостой ашигт үе давхаргын түвшинд нүх гарган буудаж, цооногт тос урсаж орох боломжийг бүрдүүлдэг.

Цооногийн туршилт, үйлчилгээний ажлын үед тос ус зэрэг асгарах эрсдэл гарах магадлалтай тул цооногийн эргэн тойронд шаардлагатай хэсгүүдэд шингэн үл нэвчүүлэх хальс дэвсэж, хөрсийг хамгаалах шаардлагатай. Өрмийн ажил дууссаны дараа өрөмдлөгийн цамхгийг туршилтад цаашид ашиглах эсвэл нүүлгэж, өөр үйлчилгээний цамхгийг байрлуулах ба туршилтын ажлыг эхлүүлнэ.

Цооног туршилтын ажлын төлөвлөгөө

Цооногт туршилт хийх шийдвэрт хүрсэн тохиолдолд өрөмдлөгийн талбайг нөхөн сэргээхээс өмнө туршилтын ажлыг өрөмдлөгийн талбай дээр хийх юм. Өрөмдлөг дууссаны дараа өрөмдлөгийн анги, зарим тоног төхөөрөмж, машин техникүүд талбайг орхих бөгөөд өрөмдлөгийн үед ашиглагдаж байсан 150м x 200м буюу 3 га талбай болон түүний гадна хашаа, өрөмдлөгийн шингэний зумф, жорлонгийн нүх, хог хаягдлын цэг, машины зогсоол зэрэг нь туршилтын ажилд ашиглагдах юм.

Ингэхдээ туршилтын үед цооноогоос гарч ирэх газрын тосгүй шингэнийг шингэн хаягдлын зумфад цуглуулах юм.

Үйл ажиллагааны дараалал

- Цооногийн үйлчилгээний цамхаг, бусад тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, кемпийг өрөмдлөгийн талбай руу авчрах, угсрах
- Бүх тоног төхөөрөмжүүдийн болон кемпийн хэвийн, аюулгүй ажиллагааг шалгаж, баталгаажуулна. Шингэний эргэлдэх систем болон оргилолтоос хамгаалах төхөөрөмжийн битүүмжлэлийг шингэний даралтаар туршиж баталгаажуулна.
- Цооног доторх шингэнийг туршилтанд зориулсан шингэнээр¹ сольж угаана. Энэ нь ойролцоогоор 5 хүртэлх хувийн эрдэс давс агуулсан ус байдаг.
- Туршилт хийгдэх давхарга перфораци хийн бэхэлгээний янданд нүхнүүд гаргана (ингэснээр тус давхаргаас цооног руу шингэн урсах боломжтой болно).
- Перфораторыг цооногоос татан гаргаж, олборлолтын янданд суурилуулсан туршилтын далд төхөөрөмжүүдийг цооногт оруулан туршилтыг эхлүүлнэ. Үүнд цооногийн ёроолд байрлуулсан хавхлагыг хэд хэдэн удаа нээж хаах үйлдлийг давтан даралтын бичиглэлийг үйлддэг.
- Туршилтын явцад ундрага бага байх тохиолдолд олборлолтын яндан дотуур бүлүүрт багаж оруулан татах аргаар цооногийн урсгалыг дэмжиж өгнө.
- Олборлосон шингэнийг шингэн хадгалах савнуудад тосож аван хуримтлуулна. Шингэний хэмжээг хангалттай нарийвчлалтайгаар богино хугацааны интервалуудад бүртгэнэ. Шингэнээс дээж авна.
- Тус давхаргын туршилт дуусмагц туршилтын далд төхөөрөмжүүдийг олборлолтын туршилтын яндангийн хамт цооногоос гаргана. Шаардлагатай үед олборлолтын яндан дахь шингэнийг эхлээд туршилтын шингэнээр угааж солин цооногийг тогтворжуулсны дараа туршилтын янданг цооногоос татаж гаргана.
- Хэрэв нэгээс олон давхаргад туршилт хийх бол дээрхийн адил туршина. Харин ингэхдээ хоёр дах пакер эсвэл түр бөглөөс ашиглаж бусад перфораци хийгдсэн доод давхаргуудыг тусгаарлана.
- Цооногийн туршилтын үр дүн дээр үндэслэж дараах алхмуудын нэг хийгдэнэ:
 - Цооногийг бүрмөсөн битүүмжилж хаан талбайг нөхөн сэргээнэ,
 - Цооногийг түр хаан талбайн нөхөн сэргээлтийн ажлыг эхлүүлнэ, олборлолтод бэлтгэн шилжүүлнэ
 - Шингэн хагалбарын ажлыг шаардлагатай үе, давхаргуудад хийнэ, шаардлагатай тохиолдолд хагалбарын дараах туршилт, шавхалтын ажил хийнэ, цооногийг түр хаан талбайн нөхөн сэргээлтийн ажлыг эхлүүлнэ. Шаардлагатай тохиолдолд туршилтын олборлолтод бэлтгэн шилжүүлнэ.

¹ Туршилтын шингэнийг гүйцээгч/гүйцэлдүүлэх шингэн гэж мөн нэрлэдэг.

Хүснэгт 1. 2. Туршилт, үйлчилгээнд ашиглах техник, тоног төхөөрөмж

Тоног төхөөрөмж кемп ²	Техникийн мэдээлэл	Тоо ширхэг
Цооногийн үйлчилгээний цамхаг	Төрөл: XJ450 Өргөх даац: 80 тонн Цамхгийн өндөр:34 м Жин: 55 тонн Хөдөлгүүр: Дизель	1
Оргилолтоос хамгаалах 2 хаалттай төхөөрөмж	Төрөл: 7 1/16" X5000	1
Оргилолтоос хамгаалах дугуй төхөөрөмж	Төрөл: 7 1/16" X5000	1
Оргилолтоос хамгаалах төхөөрөмжийн удирдлага	Төрөл: FKQ320-4	1
Шингэний насос	Төрөл: QZB35-16 5000 psi Хөдөлгүүр: Дизель	1
3 фазын сеператор / Ус, тос, хий ялгагч төхөөрөмж/	10 МПа	1
Хэмжих сав	20 м ³	1
Техникийн усны сав	40 м ³	1
Шингэний сав	40 м ³	1
Бохирын сав		1
Түлшний сав	20 м ³	1
Дизель генератор	200 кВт	1
Дизель генератор	104 кВт	1
Амьдрах чингэлгүүд	40 ft	6
Амьдрах чингэлгүүд	25 ft	6
Агуулах (чингэлэг)	40 ft	2
Ариун цэврийн чингэлэг	20 ft	1
Гал тогооны чингэлэг	25 ft	1

Каротажийн судалгаа: Туршилтын ажил эхлэхийн өмнө өрөмдлөг дууссаны дараа цооногийн геофизик судалгаа буюу каротаж хийдэг ба энэ нь давхаргын нүх сүвшил, түүнд тос, ус, хий оршин буй эсэхийг тодорхойлох зорилготой юм. Каротажийн судалгааг цацраг идэвхт эх үүсгэвэр ашиглан явуулна. Цацраг үүсгэврийн ажлыг мэргэжлийн, тусгай зөвшөөрөл бүхий туслан гүйцэтгэгч компаниар гүйцэтгүүлэх ба тус компани нь цацраг үүсгэвэр хадгалах, тээвэрлэх, ашиглахтай холбоотой МУ-д мөрдөгдөж байгаа бүхий л хууль журмыг баримтлан ажиллана.

1.6. Шингэн хагалбар

Цооногийн мөргөцөг орчмын буюу тостой үеийн чулуулгийн нүх сүв, ан цавыг сэргээх буюу шинээр нүх сүв, ан цав үүсгэж, олборлолтын цооногийн ундаргыг нэмэгдүүлэх зорилгоор хураагуурын тостой үе рүү даралттай шингэн шахаж, сэргэсэн болон шинээр үүссэн нүх сүв, ан цавыг буцаж анихаас сэргийлэн, механик шинж чанар сайтай байгалийн элс эсвэл хиймэл элс шахах аргыг практикт өргөн хэрэглэдэг ба үүнийг цооногт шингэн хагалбар хийх гэж нэрлэдэг. Энэхүү технологийг газрын тосны салбарт 1947 оноос ашиглаж эхэлсэн бөгөөд Монгол улсад нийт цооногуудын 50-аас дээш хувьд хийж байна.


Шингэн хагалбарын ажлыг ажлын шингэн шахагч өндөр даралтын тусгай зориулалтын шахуурга бүхий машинууд, мөн тусгай зориулалтын ажлын агент буюу проппант шахагч машин, мөн шахалтын даралт болон газрын гүний буюу давхаргын даралт, ажлын явц, үргэлжлэх хугацаа

² Өрөмдлөгийн үр дүнгээс хамаарч хэрэглэгдэх тоног, төхөөрөмж, кемп зэрэг нь энд тусгаснаас ондоо байх боломжтой.

зэргийг хянаж байх зэрэг зориулалттай ажлыг удирдах компьютержүүлсэн машинуудаар тус тус гүйцэтгэдэг. Уг ажлыг эхлэхийн өмнө буюу урьдчилан, өндөр даралтын хамгаалах толгойг тухайн цоонгогт суулгана. Үүний дараа ажлын агентуудыг шахагч машинаар нэгэн зэрэг газрын гүн рүү даралтаар шахаж, цооног орчинд газрын тост давхаргад ан цав, нүх сүвшилт үүсгэж, газрын тосны агуулсан чулуулгийн нэвчүүлэмжийг сайжруулах зорилгоор явуулна.

Шингэн хагалбарын ажлыг дараах 4 үе шаттайгаар явуулдаг. Үүнд:

1. Агуулагч чулуулгийн нүх сүв, ан цавыг сэргээж, тэлэх, шинээр үүсгэхийн тулд цооногт даралттай ажлын шингэн шахах,
2. Цооног уруу том ширхэгтэй сайн соортлогдсон, сайн хэлбэржсэн, механик шинж чанар сайтай элс (пропант) агуулсан тээвэрлэгч шингэнийг шахах,
3. Цооногт шахсан элсээ хураагуурын гүн рүү түрэх шингэнээр шахаж түрэх,
4. Шингэн хагалбарын дараах шингэнийг шавхалтаар цооногоос гаргах.



Зураг 1.11. Шингэн хагалбар хийх ажлын бүдүүвч

Цооногийн шингэн хагалбарын ажилд ашиглах техник, тоног төхөөрөмжийн жагсаалтыг Хүснэгт 1.6 -д үзүүлэв. Түүнчлэн цооногийн туршилтын ажилд ашиглагдаж буй дээр дурдсан тоног төхөөрөмжүүд мөн ашиглагдах болно.

Хүснэгт 1.3. Шингэн хагалбарт ашиглах тоног төхөөрөмж

Тоног, төхөөрөмж ³	Техникийн мэдээлэл	Тоо ширхэг
Шингэн хагалбарын тусгай зориулалтын өндөр даралтын шахуургат машин	Төрөл: Benz FC-2251 эсвэл Kenworth C500B Даац: 20 тонн	8
Шингэн хагалбарын тусгай зориулалтын холигч машин	Төрөл: Benz MC-70 эсвэл Kenworth C500B Даац: 20 тонн	1
Шингэн хагалбарын ажлын шингэний цистерн	Төрөл: Dongfeng DFL1311 Даац: 31 тонн	14
Элс /пропант/ тээвэрлэлтийн машин	Төрөл: Shaanxi SX3254BM384 эсвэл Steyr SX3240 Даац: 25 тонн	4
Хэмжилт, удирдлагын машин	Төрөл: Benz SEV5131TYB эсвэл Kenworth T300 3VKMHD74X26 Даац: 10 тонн	1

³ Өрөмдлөг, туршилтын ажлын үр дүнгээс хамаарч хэрэглэгдэх тоног, төхөөрөмж нь дээр тусгаснаас ондоо байх боломжтой.

Тусгай зориулалтын халаагч машин	Төрөл: Dongfeng DQJ5140TQL-1 Даац: 12 тонн	1
Тусгай зориулалтын халаагч машин	Төрөл: Huanghai dd5150xCC эсвэл Yetuo DQG5150XCC Даац: 4 тонн	1

Шингэн хагалбараас буцааж олборлосон шингэнийг хаягдлын сан (зумп)-д хуримтлуулж, технологийн дагуу ууршуулах, саармагжуулах ажлууд хийгдэх ба энэхүү буцааж олборлосон шингэнийг тусгай зөвшөөрөл бүхий байгууллагад гэрээгээр хүлээлгэн өгч зайлуулах арга хэмжээг авна.

1.6.1. Тэсрэх бодисын хэрэглээ

Цооногийн туршилтын үед хийгдэх перфорацийн ажилд бага хэмжээний тэсрэх бодис ашиглана. Тэсрэх бодисын нэр төрөл

- Эмульсийн тэсрэх бодис
- Энгийн тэсрэх бодис буюу АНФО
- Гексоген (циклотриметилентринитрамин, RDX)

Перфорацийн үе шатанд ашиглах химийн бодис ашиглалт, тээвэрлэлт, хадгалалт хамгаалалтыг тухайн ажлыг гүйцэтгэж буй тусгай зөвшөөрөл бүхий туслан гүйцэтгэгч байгууллагууд хариуцан ажилладаг.

1.6.2. Цацраг үүсгүүрийн ашиглалт

Газрын тосны хайгуулын “Онги V” талбайд хийгдэх үйл ажиллагааны хүрээнд цооногийн өрөмдлөгийн ажил дууссаны дараа цацрагийн үүсгүүр ашиглан каротажийн буюу цооногийн геофизикийн хэмжилт хийнэ. Энэ нь цооногийн геологийн тогтоц болон газрын тосны үе давхаргыг илрүүлэх зорилготой ба мэдрэгч бүхий зондыг цахилгаан утастай ган татлагаар цооног руу буулган, хэмжилт хийнэ.

Энэ талын судалгаанд мэргэжлийн, тусгай зөвшөөрөл бүхий ААН “Галакси Гео Монголиа” ХХК-тай хамтран ажиллах ба үүнд доорх нэр төрлийн цацрагийн үүсгүүрийг ашиглана. (Хүснэгт 1.4).

Хүснэгт 1. 4. Цацрагийн үүсгүүрүүд

№	Нуклейн нэр төрөл	Импортолсон огноо	Үйлдвэрээс гарсан идэвхжил Вq	Улсын дугаар
1	Америкум Am -241 / Берилли Be	2009.05.16	7.40E+11	0400AB278322/165#
2	Каезим Cs -137	2009.05.16	5.55E+10	0108CS009734/223#
3	Америкум Am -241 / Берилли Be	2009.05.16	1.85E+10	0402AB278534/187#

1.7. Эрчим хүчний хангамж

3 хэмжээст чичирхийллийн судалгаа болон өрөмдлөгийн үйл ажиллагаа эхлэх үед ажилчдын байнгын суурин бий болж ахуйн болон технологийн хэрэглээний эрчим хүчний хэрэглээг цахилгаан мотор ашиглаж шийдвэрлэх ба өрөмдлөгийн үед 700 кВт-ын хүчин чадалтай 3 ширхэг дизель генераторууд ашиглаглахаар төлөвлөсөн ба эрчим хүчний асуудлыг өрөмдлөгийн болон сейсмийн гэрээлэгч компаниар гүйцэтгүүлж, захиалагч тал хяналт тавьж ажиллана.

1.8. Ажилчдын тоо, ажиллах горим

Төсөл хэрэгжих хугацаанд Капкорп Монголиа ХХК-аас 8 ажилтан, АМГТГ-ын төлөөлөгч 1, туслан гүйцэтгэгч компанийн инженер техникийн ажилтнууд болох туршилтын ил, далд төхөөрөмжүүдийн инженер мэргэжилтнүүд, перфорацийн мэргэжилтнүүд, цахилгаанчин, механикч, гагнуурчин, цамхгийн менежер, өрөмдлөг, туршилтын супервизор, өрөмдлөг туршилтын инженер, өрөмдлөг туршилтын мастер, өрөмдлөг туршилтын ажилтан, туслах ажилтан (орон нутгаас авах ажилчдыг оруулаад), ажиллахаар төлөвлөж байна. Үүнд ажлын үе шат дахь ажилчдын тоог Хүснэгт 1.3-д үзүүлээ:

Хүснэгт 1. 2. Ажлын үргэлжлэх хугацаа болон ажиллах хүчний нэгдсэн мэдээлэл

Ажлын үе шат	Ажлын үргэлжлэх хугацаа (хоног)	Ажиллах горим	Ажилчдын тоо
3 хэмжээст чичирхийллийн судалгаа	30	2 ээлжээр 24 цаг	250
Цооног өрөмдлөг	60	2 ээлжээр 24 цаг	80
Цооног туршилт	60	2 ээлжээр 24 цаг	57
Шингэн хагалбар	39	2 ээлжээр 24 цаг	64
Олборлолтын туршилтын ажил	60	2 ээлжээр 24 цаг	9

1.9. Усны эх үүсвэр ба ус хэрэглээ

Өрөмдлөгийн үед ашиглагдах техникийн усны хэрэглээг 2018 онд Гучин-Ус сумын нутагт гаргасан өөрийн худгаас авч ашиглахаар төлөвлөөд байна.

БОНХАЯ-ны Сайдын 2015 оны 07 дугаар сарын 30-ны өдрийн А/301 тушаалын “Газрын тосны салбарын усны норм”-ын дагуу авч үзэхэд, өрөмдлөгийн шингэнийг бөөнөөр бэлтгэх үед хоногт 43 м³ ус хэрэглэх нормоор тооцоолсон.

Хүснэгт 1. 3. Газрын тосны эрэл хайгуул, олборлолтын өрөмдлөгийн ус зарцуулалтын норм (Өрөмдлөг хийх хоног тутамд 1 цооногт)

Ус хэрэглээний зориулалт	Ус зарцуулалтын норм, м ³
Шавар уусмал хэрэглэн өрөмдөхөд:	
Уусмалыг бөөнөөр бэлтгэх үед	43.0
Уусмалыг тусгайлан бэлтгэх үед	72.0
Ус хэрэглэн өрөмдөхөд:	
Хоногт 1.75-8 цаг өрөмдөхөд	225.0
Цооногийн их засвар хийх үед	3.0

Тус өрөмдлөгт шавар уусмал хэрэглэн өрөмдлөг хийх тул усны нормыг хоногт 43.0 м³ байхаар тооцов.

Хүснэгт 1. 4. Технологийн хэрэгцээнд ашиглах усны хэмжээ, тн

№	Цооногийн гүн, м	Хугацаа, хоног	Хэмжих нэгж	Ашиглагдах усны хэмжээ, тн		
				Сард	Өдөрт	Нийт
1-р цооног						
1.	1500-2000	30	тн	1290	43	1290
2-р цооног						
2.	1500-2000	30	тн	1290	43	1290
Нийт						2580

Өрөмдөх цооногуудад хийх туршилтын ажлын техникийн усны хэрэглээ /Туршилтын ажил хийгдэх эсэх нь тодорхой бус байгаа/

- Цооног дахь шингэнийг туршилтын шингэнээр солиход цооногийн эзэлхүүнтэй ижил хэмжээний шингэн хэрэглэгдэхээр тооцвол
 $37 \text{ м}^3 + 100\% \text{ илүүдэл} = 37 \text{ м}^3$
- Давхарга тус бүрт туршилт хийсний дараа цооногийг тогтворжуулах шаардлагатай бол олборлолтын яндангийн дотор эзэлхүүнийг 3 удаа солбиж угаахаар тооцвол
 $3 \times 9 \text{ м}^3 + 100\% \text{ илүүдэл} = 27 \text{ м}^3$

Мөн олборлолтын яндангийн металлын эзэлхүүнийг шингэнээр нөхөхөд 4 м^3 ус хэрэгтэй.

Нэг цооногт дунджаар 3 давхаргад туршилт хийнэ гэж тооцвол техникийн усны хэрэглээ нь $37 + 3 \times 27 + 3 \times 4 = 130 \text{ м}^3$ байхаар байна.

2 цооногт нийтдээ 260 м^3 техникийн ус хэрэглэхээр тооцоотой байна.

Өрөмдөх цооногуудад хийх шингэн хагалбарын ажлын техникийн усны хэрэглээ

Шингэн хагалбарын хэмжээн дээр үндэслэн 1 цооногт хийх шингэн хагалбарт 350 м^3 техникийн ус хэрэглэхээр тооцон, нийт – 2 цооногт 700 м^3 ус хэрэглэхээр байна. Шингэн хагалбар хийгдэх эсэх нь өрөмдлөг, туршилтын ажлын үр дүнгээс хамаарч шийдэгдэнэ.

Олборлолтын туршилтын ажилд ашиглах усны хэмжээ:

Газрын тосны шинж чанараас хамаарч зарим тохиолдолд цооногийг халуун ус, уураар угаах шаардлага үүсдэг. Нэг удаа угаалга хийхэд ойролцоогоор 15 м^3 ус хэрэглэгдэнэ. Олборлолтын туршилтын явцад 1 цооногийг 1 удаа угаах шаардлага үүснэ хэмээн тооцвал нийтдээ 30 м^3 ус ашиглана.

4.8.2 Зам талбайн усалгаанд ашиглах усны хэмжээ:

Технологид ашиглах усны хэмжээг тооцохдоо Монгол улсын БОНХАЯСайдын 2015 оны 07 дугаар сарын 30-ны өдрийн А/301 тушаалд тусгаснаар “Зүлэгжүүлэлт зам талбайн усалгааны нормын дагуу” тооцов.

1. Нэг цооногт

$W_{\text{зам усалгаа}} = N_{\text{зам услах}} * S$ нэг хоногийн зам талбайн усалгааны ус зарцуулалт

$N_{\text{зам услах}}$ – Зам усалгааны норм / 1 м^2 талбайд 2 л ус зарцуулна. /

S – Услах шаардлагатай талбайн хэмжээ, 2500 м^2 - Машин техник явах талбай, өрөмдлөгийн хоолой, янданг байршуулах талбай, өнгөн хөрс байрлах талбай $W_{\text{зам усалгаа}} = 2л * 2500 \text{ м}^2 = 5000 \text{ л/хон} = 5 \text{ тн/хон}$

Нийт 2 цооног өрөмдөх хугацаанд $= 5 \text{ тн} \times 12 = 60 \text{ тн}$ /5 хоногийн давтамжтай усалгаа хийхээр тооцов/

4.8.3 Унд ахуйн хэрэгцээнд ашиглах усны хэмжээ

Унд ахуйн усны хэрэгцээг тооцохдоо Монгол улсын БОНХАЯСайдын 2015 оны 07 дугаар сарын 30-ны өдрийн А/301 тушаалын дагуу “Орон сууц, нийтийн байр, гэр хорооллын усны норм”-

ын дагуу, худаг, булаг зэрэг уснаас зөөврөөр хангагддаг гэр хороололын ус хэрэглээний нормоор 20 л/хоног байхаар тооцов.

1. Сейсмийн судалгааны ажлын үеийн үнд ахуйн усны хэрэглээг тооцвол: Нийт ажиллагсад 245 хүн 30 хоног ажиллахаар төлөвлөсөн. Өдөрт 245 хүн х 10 л = 2450 л буюу 2.5 тн ус, сард 2450 л х 30 хоног = 73500 л буюу 73.5 тн усыг үнд ахуйн хэрэглээнд ашиглах тооцоо байна.

30 хоногийн ажиллах хугацаанд 73.5 тн ус ашиглах бөгөөд үндны цэвэр усыг эрүүл ахуйн шаардлага хангасан стандартын савалгаатай усаар хангаж ахуйн усыг өөрийн гаргасан худгаас зөөвөрлөн хэрэглэнэ.

2. Нэг цооногт ашиглах үнд ахуйн усны хэрэглээг тооцвол: Өдөрт 80хүн х 10 л = 800 л буюу 0.8 тн ус, сард 0.08 тн х 30 хоног = 24.0 тн ус ашиглахаар байна.

3. Хоёр цооногт ашиглах үнд ахуйн усны хэрэглээг тооцвол: Өдөрт 0.8 тн х 2 = 1.6 тн ус, сард 24.0 тн х 2 =48.0 тн, нийт: 1.6 х 60 = 96.0 тн ус ашиглахаар байна.

4. Шингэн хагалбарын ажилд ашиглах үнд ахуйн усны хэрэглээг тооцвол: Өдөрт 64 хүн х 20 л= 1280 л буюу 1.2 тн, сард 1.2 тн х 30 хоног = 36 тн

5. Олборлолтын туршилтын ажилд ашиглах үнд ахуйн усны хэрэглээг тооцвол: Өдөрт: 9 хүн х 10 л =90 л ус, сард: 60 хоног х 90л= 5.4 тн ус ашиглана.

6. Цооногийн туршилтын ажилд ашиглах үнд ахуйн усны хэрэглээг тооцвол: Өдөрт 57 хүн х 10 л= 570 л ус, сард 0,57 тн х 30 хоног = 17.1 тн ус х 2 сар = 34.2 тн ус ашиглахаар байна.

Хүснэгт 1. 5. Үнд ахуйн хэрэгцээнд ашиглах ус

Д/д	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Тоо хэмжээ тн
Сейсмийн судалгааны ажлын үед			
1.	Өдөрт	тн	2.5
2.	Сард	тн	73.5
3.	Нийт	тн	73.5
Цооног өрөмдлөгт			
1.	Өдөрт	тн	3.2
2.	Сард	тн	96.0
3.	Нийт	тн	96.0
Шингэн хагалбарын ажилд			
1.	Өдөрт	тн	1.2
2.	Сард	тн	36.0
3.	Нийт	тн	36.0
Олборлолтын туршилтын ажилд			
1.	Өдөрт	тн	0.9
2.	Сард	тн	5.4
3.	Жилд	тн	5.4
Цооногийн туршилтын ажил хийгдвэл			
1.	Өдөрт	тн	0.57
2.	2 сард	тн	34.2
3.	Нийт	тн	34.2
НИЙТ			245.1

Жич: Зөвхөн үнданд савалгаатай цэвэр ус хэрэглэх тул энд ахуйн хэрэглээний усыг хоногт 1 хүнд 10л-ээр тооцсон. Ахуйн хэрэглээний усыг худгаас зөөврөөр ашиглана.

Хүснэгт 1. 6. Нийт ус хэрэглээний дүн

Д/д	Зориулалт	Хэмжих нэгж	Өдөрт	Ажлын хэмжээ /хоног/	Нийт, тн
1.	Өрөмдлөгт	тн	43.0	60	2580.0
2.	Зам усалгаа	тн	1.0	12 удаа	60.0
3.	Ахуйн хэрэглээнд	тн	3.2	60	245,1
4.	Шингэн хагалбарын ажилд	тн	-	(цооногийн тоогоор)	700
Нийт			47.2		3585.1
Цооногийн туршилтын ажил хийгдвэл					
5.	Олборлолтын туршилтын ажилд	тн	-	(тохиолдлын тоогоор)	30.0
6.	Туршилтын ажилд	тн	-	(цооногийн тоогоор)	260.0
НИЙТ					3875.1

Жич: Хоногт 47.2 тн ус ашиглах тооцоо гарсан байна. Иймээс Усны тухай хуулийн дагуу хоногт 50 тн-оос бага ус ашиглах тул Аймгийн байгаль орчны албаар дүгнэлтээ гаргуулж зөвшөөрлөө авна.

Газрын тосны илэрц байгаад туршилтын ажил хийгдэх тохиолдолд хоног нь тусдаа тооцогдох болно.

1.10. Химийн бодисын хэрэглээ

Газрын тосны цооногийн өрөмдлөгийн үйл ажиллагаанд ашиглагдах химийн бодисуудын нэр төрөл болон хэрэглэх зориулалтыг дараах хүснэгтэнд үзүүлж байна.

Хүснэгт 1. 7. Цооног өрөмдлөгийн явцад ашиглагдах химийн бодисуудын нэр

№	Англи нэр	Монгол нэр	Химийн томъёо	Хэмжээ тн	
				1 цооногт	Нийт
1	Barite	Барит	BaSO ₄	120	240
2	Compound ammonium salt of hydrolytic polyacrylonitrile NH ₄ -HPAN-2	Гидролитик поликрилонитрил аммоны нэгдэл	NH ₄ (C ₄ O ₂ NH ₃)N	20	40
3	Technical requirements of phenol urea-formaldehyde resin for drilling fluid SN-SZ	Өрөмдөх шингэний фенол шүлтлэг формальдегидийн давирхай техникийн техникийн шаардлага SN-SZ	C ₃ H ₈ N ₂ O ₃	24	48
4	Anti salt composite filtration reducing agent branched resin	Угаалгын шингэнд тунадас үүсэлтийг бууруулагч бодис	(C ₃ H ₆ O ₂) N (CO ₂ H) nM	24	48
5	Potassium hydroxide	Калийн гидроксид	KOH	4	8
6	Zwitterionic polymer encapsulation used with drill fluid	Угаалгын шингэний шинж чанарыг сайжруулагч бодис	(NH ₂ CHNH ₂ C HCOONH ₂) n	6	6

7	Zwitterionic polymer thinner used with drilling fluid Cellulose)	Угаалгын шингэний шинж чанарыг сайжруулагч бодис (целлюлоз)	Na2 (C4O2NH3) n SO3	6	12
8	Calcium Carbonate ultra-fine	Нарийн ширхэгт кальцийн карбонат	CaCO3	24	48
9	Soda ash	Зэврэлтийн нөлөөллийг багасгах зорилгоор ашигладаг бодис	Na2CO3	2.5	5
10	Carboxymethyl cellulose LV-CMC	Carboxymethyl целлюлоз LV-CMC	[C6H7O2(OH) 2OCH2COO Na]n	6	6
11	Bentonite used with drilling fluid	Бентонит	AL2O3.4SiO2. 3H2O	40	80
12	Drilling fluid synthetic plugging agent acid soluble and pressure-bearing compound YTZ	Угаалгын шингэний хувийн жинг хүндрүүлэгч бодис	BASO4(C5H8 O4)N	40	80
13	Amine base inhibitors ZJ-1	Амино нэгдлийг саармагжуулагч бодис ZJ -1	HO(C2H4O)m(C3H6O)n	18	36
14	Defoamer for Drilling	Угаалгын шингэний хөөсрөлтийг бууруулагч бодис	CH3(SiOH)3	0.24	048
15	Anti-sloughing Agent for Drilling Fluid, White Asphalt	Өрөмдлөгийн шингэний нуралтаас хамгаалах бодис, цагаан асфальт	(C5H9NO4)n	24	48
16	Zinc carbonate	Цайрын карбонат	C2H8O13Zn5	2	2
17	Cationic Clay Stabilizer NW-1	Шаварлаг үеийг нурахаас сэргийлж, тогтворжуулагч бодис NW-1	(-Si-O-Si) n	3	6
18	Cationic Polymer Shale inhibitor HX-D for Drilling Fluid	Шатамхай занарыг ионжуулагч /катион/ нийлмэл бодис	(C8H16NCl)n	5	10
19	CF40S Dispersant	CF40S Dispersant	C20H24Na2O1 0S2	2.4	4.8
20	BCF-200S Fluid loss agent	BCF-200S Шингэн алдагдлын багасгагч	(C7H13NO4S) х.(C3H4O2)y	7.7	15.4
21	GH6 Retarder	GH6 өрөмдлөгийн шингэний урсгалыг удаашруулагч бодис	C6H11O7Na	0.46	0.92
22	G603 Defoamer	G603 Угаалгын шингэний хөөсрөлтийг бууруулагч бодис	C17H27O4P	0.24	0.48
Дүн					

1.11. Өрөмдөх цооногуудад хийх шингэн хагалбарын ажилд хэрэглэх химийн бодисын хэрэглээ

Өрөмдөх 2 цооногт тус бүрт нь гурван давхаргад шингэн хагалбар хийхээр нийт ажлын хэмжээ, нийт хэрэглэгдэх химийн бодисын хэрэглээг доорх хүснэгтэд үзүүлээ.

Хүснэгт 1. 8. Шингэн хагалбарын ажилд хэрэглэх химийн бодис

№	Англи нэр	Монгол нэр	Химийн томьёо	Хэмжээ	CAS дугаар
1	Guar	Гуар	$[C_6H_7O_2(OH)_2.O.CH_2CH_2CH_2OH]_n$	36 тонн	39421-75-5
2	Soda ash	Техникийн сод	Na_2CO_3	9 тонн	497-19-8
3	Edible sodium	Натрийн гидрокарбонат	$NaHCO_3$	3.6 тонн	144-55-8
4	Demulsifier	Эмульсгүйжүүлэгч	$C_{18}H_{37}O(C_3H_6O)_{35}(C_2H_4O)_{273}(C_3H_6O)_{31}H$	5.4 тонн	9010-79-1
5	Organic boron	Органик бор	$B[CH_3COCH_2C(CH_3)O]_4$	18 тонн	150-46-9
6	Breaker	Задлагч хольц	$Na_2S_2O_3$	1.8 тонн	?
7	Potassium persulfate	Калийн персульфат	$K_2S_2O_8$	3.6 тонн	7727-21-1
8	FH-2 anti-swelling agent	FH-2 хавагнахаас хамгаалагч	$-[-CH_2-CH-]_m-[-CH_2-CH-]_{n-1}CONHC(CH_3)_2CH_2SO_3H$ CONH	18 тонн	26590-05-6
9	WDJ clay stabilizer	Шавар бэхжүүлэгч WDJ	$-[-CH_2-CH-]_m-[-CH_2-CH-]_{n-1}CONHC(CH_3)_2CH_2SO_3H$ CONH	18 тонн	124-09-4
10	Cleanup additive	Цэвэрлэгээний нэмэлт бодис	$C_7H_{15}COONaC_{12}H_{25}SO_4Na(CH_3)_2CHOH$	9 тонн	2386-53-0

Хүснэгт 1. 9. Цооногуудад хийх туршилтын ажилд хэрэглэх химийн бодисын хэрэглээ

№	Англи нэр	Монгол нэр	Хэмжээ	Химийн тэм.	CAS дугаар
1	Potassium chloride (KCl)	Калийн хлорид (KCl)	104 тонн	KCl	-
2	Bactericid/Corrosion inhibitor	Зэврэлтээс сэргийлэгч	1230 литр	$C_{19}H_{42}ClN$	112-02-7
3	Defoamer	Хөөсрөлт бууруулагч	3060 литр	$C_{17}H_{27}O_4P$	-
4	Oxygen scavenger	Хүчилтөрөгч шингээгч	1230 литр	Na_2SO_3	-
5	Oxygen scavenger	Хүчилтөрөгч шингээгч	1230 литр	$(NH_4)HSO_4$	-
6	Methanol	Метанол	3060 литр	CH_3OH	-

Химийн бодисын агуулахын дүгнэлт болон химийн бодис ашиглах тусгай зөвшөөрлийг өрөмдлөг, туршилт, шингэн хагалбарын ажлын гэрээт гүйцэтгэгч байгууллага үйл ажиллагааныхаа хүрээнд хариуцан гэрээгээр зохицуулж ажиллана.

ХОЁР. ТӨСЛИЙН ТАЛБАЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ ТӨЛӨВ БАЙДАЛ


2.1. Физик газарзүйн нөхцөл

Хайгуул судалгааны ажил явагдах талбайн Өвөрхангай аймгийн баруун урд хэсгийн говийн бүсэд Зүүн богдын ар хоолойд, их элсний захад, Цагаан нуурын хойд дэнж дээр оршдог. Баруун талаараа Баянхонгор аймгийн Богд сумтай, хойд талаараа Нарийнтээл, зүүн хойд талаараа Хайрхандулаан, зүүн талаараа Гучин-Ус, урд талаараа Богд сумтай хил залгаа нутагтай. Улаанбаатар хотоос 605 км, Арвайхээр хотоос 175 км зайд байрладаг.

“Капкорп Монголиа” ХХК-ийн өрөмдлөгийн талбай нь Өвөрхангай аймгийн Баруунбаян-Улаан сумын нутгийн баруун урд хэсэгт 3 га орчим газрыг хамрах бөгөөд, өрөмдлөгийн талбай нь цөлийн хээрийн бүс нутаг, Рамсарын конвенцид бүртгэлтэй Нууруудын хөндийн тойрогт хамаарах ба газрын гадаргуу нь 1202.7-1585м далайн түвшнээс дээш өргөгдсөн ба төслийн талбайд улсын тусгай хамгаалалттай газар нутаг байхгүй ч хамгийн ойр “Говь гурван сайхан уул” Байгалийн цогцолбор газар 100 км зайд байрлана.



Зураг 2. 1. Өрөмдлөг хийх талбайн орчны харагдах байдал



Зураг 2. 2. Монгол орны физик-газарзүйн зураг

2.2. Уур амьсгалын нөхцөл

Уур амьсгалын мужлалын хувьд хайгуулын талбайн өмнөд хэсэг гандуу дулаан зун, хүйтэн өвөлтэй, төвийн хэсэг хуурай сэрүүвтэр зун хүйтэн өвөлтэй, хойд хэсгээрээ хуурайдуу сэрүүн зун хахирдуу өвөлтэй мужид хамаарна. Нарны цацрагийн ажиглалтын мэдээгээр жилд дунджаар 273 өдөр, сард 23 өдөр цэлмэг, нарны гийгүүллийн үргэлжлэх хугацаа жилдээ 3026 цаг, зуны улиралд 283-290 цаг, өвлийн улиралд 213-220 цаг, нийлбэр 4099.3 мДж/м², өвлийн улиралд бага /12-р сард 141.2 мДж/м². Агаарын жилийн дундаж хэм 50С-60С, жилдээ 100мм-120мм тунадас унадаг. Хойд болон зүүн хойд зүгийн салхи ноёлдог, жилийн дундаж салхины хурд 2.7 м/с – 3.6 м/сек байдаг байна.


Төсөл хэрэгжих Өвөрхангай аймгийн Гучин-Ус, Баруунбаян-Улаан сумдын нутаг нь Говь-Алтайн нуруу, Хангайн нурууны хооронд орших далайн түвшнээс дээш 1000-2500м өндөрт өргөгдсөн Нууруудын хөндийн гандуу, дулаан зунтай, хүйтэн өвөлтэй цөлийн хээрийн бүсэд хамаарах ба хуурай уур амьсгалтай; жилдээ 114-134мм орчим тунадас унадаг, чийгийн хэмжээ бага, жилийн дундаж харьцангуй чийгшил 43-47 орчим хувь, агаарын температурын жилийн дундаж 3.0-4.4 градус, хүчтэй салхи, цасан ба шороон шуурга зэрэг цаг агаарын аюулт үзэгдлүүд олонтой тохиолддог.

Цаг уур, уур амьсгалын үндсэн 40 орчим үзүүлэлтүүдээс дүгнэж үзэхэд газрын тосны хайгуулын өрөмдлөгийн үйл ажиллагаа явуулах Гучин-Ус, Баруунбаян-Улаан сумдын нутаг дэвсгэр нь гандуу дулаан зунтай, хүйтэн өвөлтэй уур амьсгалын мужид хамаарах бөгөөд чийгшилт нь 5.6% -аас их, дулааны хангамж буюу 10 цельсээс дээшхи хоногийн агаарын дундаж температурын нийлбэр 3000-аас дээш юм.

2.3. Хөрсөн бүрхэвч

Нийт талбайн хэмжээнд хөрс нь олон хэв шинжийг агуулсан ба байгаль орчны хяналт шинжилгээний ажлаар хяналтын зурвас газарт уулын, тал хөндийн, бүс дундын гэсэн хөрсний хэв шинж тодорхойлогдсон. Мөн Өвөрхангай аймгийн өмнөд, Дундговь аймгийн баруун хэсгийн нутаг нь хөрс газарзүйн мужлалаар хөрс био уур амьсгалын Хангайн их мужийн өргөргийн бүсчлэл бүхий хүрэн хөрстэй.

Өвөрхангай аймгийн Гучин-Ус, Баруунбаян-Улаан сумдын нутаг нь хөрс газарзүйн мужлалтаар говийн их мужийн, говийн бор хөрсний бүсийн, хойт говийн мужийн нууруудын хөндийн бүсэд хамаарах бөгөөд төсөл хэрэгжих талбайн орчинд цайвар хүрэн, говийн бор хэвшинжит хөрс тархсан байна.




Зураг 2. 3. Монгол орны хөрсөн бүрхэвчийн зураг

2.4. Гадаргын ус

Хайгуулын талбайд цөөн тооны гол горхи байдгаас хамгийн том нь Онги, Ар агуйтын гол бөгөөд Ар агуйт голын сав Хайрхандулаан, Гучин-Ус, Төгрөг сумдын нутгаар 185 км урсаж, Эрэн уулын ар хонхорт цутгадаг. Онги голын сав нь Хангайн нурууны өврөөс эх авч 435 км урсахдаа 52 920 км талбайгаас усжин Улаан нуурт цутгана.

Төсөл хэрэгжих нутгийн ус зүйн сүлжээг Хангайн нурууны баруун урд хэсгээс эх аван урсдаг Таац гол болон түүгээр тэжээгддэг Таацын цагаан нуур тэдгээрийн орчимд шүүрч гардаг булаг шандууд бүрдүүлдэг.



Зураг 2. 4. Монгол орны гидрогеологийн зураг

2.5. Амьтны аймаг

Талбайн амьтны аймгийн судалгаагаар энэ бүс нутагт 7 баг 16 овогт хамаарах 49 төрлийн 72 зүйл хөхтөн, 70 гаруй зүйлийн загас, 370 гаруй зүйлийн жигүүртэн шувуу, 20 гаруй зүйлийн дархан цаазат ан амьтад тархан амьдарна. Үүнээс CITES-д орсон 16 зүйл, МУН-д орсон 14 зүйл, хамгаалагдсан ховор амьтдын жагсаалтад 15 зүйл бүртгэгдсэн байна.

Талбайн амьтны аймгийн судалгаагаар энэ бүс нутагт 3 баг, 6 овогт хамаарах 12 зүйл хөхтөн, 14 гаруй зүйлийн жигүүртэн шувуу, 1 овогт хамаарах 3 зүйл шавьж, 1 овогт хамаарах, 1 зүйл мөлхөгч амьтад тархан амьдарна. Үүнээс CITES-д орсон 7 зүйл, МУН-д орсон 8 зүйл, хамгаалагдсан ховор амьтдын жагсаалтад 8 нийт зүйл бүртгэгдсэн байна.

2.6. Ургамлан нөмрөг

Газрын тосны хайгуулын Онги V талбай нь монгол орны ургамал газарзүйн мужлалаар Монголын цөл, хээрийн хошууны Умард говийн цөлөрхөг хээрийн дэд хошуунд багтах бөгөөд Олон нуурын хөндийн цөлөрхөг хээрийн тойрогт хамрагддаг. Хяналт судалгааны зурвасын дагуу 10 бүлгэмдэлд хамаарах 38 зүйл ургамал бүртгэгдсэн ба үүний дотор аж ахуйн ач холбогдол бүхий 20 зүйл ургамал байна.

Өвөрхангай аймгийн Гучин-Ус, Баруунбаян-Улаан сум нь ургамал газарзүйн мужлалаар Дорноговийн цөлөрхөг хээрийн тойрогт оршино. Гучин-Ус сумын нутаг нь Хангайн уулын хээр, баруун ба баруун өмнөөс Говь-Алтайн уулын цөлөрхөг хээр, зүүнээсээ Дундад халхын хуурай хээрийн ургамлууд холилдон ургана. Хайгуулын цооног өрөмдөх талбай орчмын газар нутагт цөлийн хээрийн заримдаг сөөгөнцөр-үетэн-таана зонхилно.

Төсөл хэрэгжих талбайд 2 бүлгэмдэл давамгайлж байна. Үүнд:

Хотир – улаан бударганат бүлгэмдэл. (*Zygophyllum xanthoxylon*, *Reaumuria soongarica*)
Хялгана – орог тэсэгт бүлгэмдэл. (*Stipa caucasica subsp. glareosa*, *Krascheninnikovia ceratoides*)

Геоботаникийн судалгааны үр дүнд 10 овог 22 төрөл 29 зүйлийн ургамал бүртгэсэн.

2.7. Геологийн тогтоц

Дүүргийн талбайн баруун хойд хэсэг нь Хангайн синклинорид, зүүн хойд хэсэг нь Хархорины өргөгдөлд, Өмнөд хэсэг нь Төв Монголын антиклиналь бүсийн Байдрагийн өргөгдөлд, Онгийн голын депрес, мөн Өмнөд Монголын Говь-Алтайн өргөгдөлд хамаарна. Хангайн синклинорийн хэмжээнд доод-дунд девоны Эрдэнэцогтын дунд-дээд девоны Цэцэрлэгийн доод-дунд карбоны Жаргалантын ховороор юрагийн, неогений хурдас тархснаас гадна дөрөвдөгчийн хүрмэн чулуу уулын орой болон хөндийгөөр тархсан. Гүний чулуулгаас үндсэндээ хожуу карбоны Хангайн бүрдлийн боржин-боржиндиорит, багаар хожуу, триас-түрүү юрын Шар ус голын бүрдлийн шүлтлэг боржин тархсан.

Хархорины өргөгдлийн хэмжээнд хожуу рифейн хувирмал чулуулаг, дээд кембри-доод ордовикийн Хараагийн серийн занарын зузаалаг, Эрдэнэцогт, Цэцэрлэг, Жаргалантын свитүүд, дээд триас-доод юрагийн хурдас тархсан бөгөөд гүний чулуулгаас дунд-хожуу кембрийн боржин, хожуу карбоны боржин-боржиндиорит, хожуу триас-түрүү юрийн Шар ус голын бүрдлийн шүлтлэг боржин, боржинсиенит тус тус тархсан.

Байдрагийн өргөгдөл, Онгийн гол депресийн хэмжээнд протерозойн болон рифейн хувирмал чулуулаг, рифейн боржин, Хараагийн серийн хурдас, дунд-хожуу кембрийн боржингоос гадна мезо-кайозойн хурдас ихээр тархсан.

ГУРАВ. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

3.1. Төслийн гол болон болзошгүй нөлөөлөл

“Капкорп Монголиа” ХХК-ийн бүтээгдэхүүн хуваах гэрээт газрын тосны хайгуулын Онги V талбайд хийгдэх 3 хэмжээт чичирхийллийн судалгаа, өрөмдлөгийн ажлын үед байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүдэд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийн шинжилгээг боловсруулахдаа байгаль орчны суурь судалгаа, хайгуулын өрөмдлөгийн технологи, өрөмдлөгийн үед хэрэглэгдэх химийн бодис, материал түүхий эдийн хэрэглээ, шинжээчдийн судалгааны дүнд тулгуурлан хийсэн болно.

Хайгуулын өрөмдлөгийн үед нөлөөлөлд өртөх газар нутгийн хэмжээ харьцангуй бага учраас төсөл хэрэгжсэнээр сөрөг нөлөөлөлд өртөгдөх байгалийн үндсэн бүрдэл нь газрын хэвлий, хөрсөн бүрхэвч, ургамлан бүрхэвч, газрын доорхи ус байх болно. Мөн дэд бүтэц төдийлөн сайн хөгжөөгүй орон нутагт өрөмдлөгийн шинж чанартай үйл ажиллагаа явуулахад ашиглагдах техник хэрэгслийн улмаас агаар орчинд үүсэх дуу чимээний түвшин өсөн нэмэгдэнэ.

Хайгуулын өрөмдлөгийн үйл ажиллагаа нь богино хугацаанд, эрчимтэй явагдаад дуусах тул хайгуулын цооног өрөмдөх, үйл ажиллагаанд шаардлагатай техник, хэрэгслийг авчрах, суурилуулах, туслах барилга байгууламж болох кемп, химийн бодисын агуулах, шатах тослох материалын агуулах зэрэг байгууламжуудыг барих бүтээн байгуулалтын үед тухайн үйл ажиллагаа явагдах талбайн ургамлан нөмрөг, хөрсөн бүрхэвчийн өнгөн хэсэгт сөрөг нөлөөллийг бий болгохын сацуу агаар орчинд дуу чимээ, дизель түлшээс ялгарах хорт хий, утаа, тоос шорооны гэх физик бохирдлуудыг үүсгэж болзошгүй юм.

3.2. Төслийн нөлөөллийн хэлбэр, эрчим, үргэлжлэх хугацаа

Төслийн байгаль орчинд нөлөөлөх нөлөөлөл, болзошгүй нөлөөллийг задлан шинжилж, дүгнэн гол сөрөг нөлөөллийг тогтоох асуудал нь байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний нэг чухал бүрэлдэхүүн хэсэг юм. Гол нөлөөллийг үнэн зөв үндэслэлтэйгээр тогтоосноор болзошгүй хохирол, сөрөг үр дагаврыг бууруулж чадахын зэрэгцээ нэмэлт судалгааны ажил, тооцооны хүрээг зохистойгоор хязгаарлах боломж гарч, зардал, хөрөнгө, цаг хугацаа хэмнэгдэнэ. Байгаль орчны үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийг магадлан жагсаах болон матрицын аргаар ОУ-ын хэмжээнд мөрдөгддөг аргачлалын дагуу хийв. Төслийн үйл ажиллагаанаас тухайн орон нутгийн байгаль орчны төлөв байдал, нийгэм-эдийн засаг, хүн амын амьдрах орчин, ажиллагсадын эрүүл мэндэд учруулах нөлөөлөл, тэдгээр нөлөөллийн хэлбэр, үргэлжлэх хугацаа, эрчимшил зэргийг тогтооход байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний магадлан жагсаах аргыг ашиглав. Нөлөөлөлд хамрагдах байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүдийг байгаль орчин, экосистемийн, байгалийн нөөцийн ашиглалт, байгаль орчны чанарын өөрчлөлт, байгалийн өнгө төрх, түүх соёлын дурсгалт зүйл, археологи, палеонтологийн олдвор, эдийн засаг, нийгмийн асуудал, бусад нөлөөлөл гэсэн 6 үндсэн бүлэгт хуваан авч үзэв. Нөлөөллийн байдлыг авч үзэхдээ сөрөг нөлөөлөл (х), эерэг нөлөөлөл (+) гэсэн байдлаар экспертүүдийн саналыг харгалзан үнэлгээ өгсөн болно/Хүснэгт 3.1/.

Хүснэгт 3. 1. Нөлөөллийн хэлбэр, үргэлжлэх хугацаа, эрчимшил

Байгаль орчны үзүүлэлтүүд	Нөлөөлөл	Шууд	Шууд бус	Богино хугацаанд	Дунд хугацаанд	Урт хугацаанд	Буцаж нөлөөлөх	Буцалтгүй нөлөөлөх	Нөлөөллийн эрчимшил			
									Сулавтар	Бага	Дунд	Хүчтэй
1. Байгаль орчин, экосистемийн өөрчлөлт												
Газрын доорхи усны нөөц, горимын өөрчлөлт		x		x				x		x		
Гадаргын усны нөөц, горимын өөрчлөлт			x	x				x	x			
Ургамлан нөмрөгийн өөрчлөлт		x		x				x		x		
Хөрсний элэгдэл, эвдрэл		x		x						x		
Зэрлэг ан амьтдын байршилт, тархалтын өөрчлөлт		x		x				x		x		
Уур амьсгал (бичил)-ын өөрчлөлт												
2. Байгалийн нөөцийн ашиглалт												
Хөрсний үржил шим			x		x			x		x		
Ахуйн зориулалтаар ашиглах усны нөөц		x		x							x	
3. Байгаль орчны чанарын өөрчлөлт												
Газрын доорх усны чанарын өөрчлөлт			x			x				x		
Гадаргын усны чанарын өөрчлөлт			x	x					x			
Агаарын бохирдол		x		x						x		
Хөрсний бохирдол		x		x						x		
Ургамлан нөмрөгийн бохирдол			x	x					x			
4. Байгалийн өнгө төрх, түүх соёлын дурсгалт зүйл, археологи, палеонтологийн олдвор												
Байгалийн унаган төрх өөрчлөгдөх			x	x					x			
Ландшафтын хэлбэр дүрс, өнгө төрх өөрчлөгдөх			x	x					x			
Тусгай хамгаалалттай газар нутагт нөлөөлөх			x	x					x			
5. Эдийн засаг, нийгмийн асуудал												
Улсын төсвийн орлого нэмэгдэх		+		+							+	
Орон нутгийн төсвийн орлого		+		+							+	
Ядуурлыг бууруулахад дэмжлэг		+		+							+	
Шинээр ажлын байр нэмэгдэх		+		+							+	
Ажиллагсдын эрүүл мэндэд			x	x						x		
6. Бусад нөлөөлөл												
Зам харилцаа, машин механизмын хөдөлгөөнөөс хөрс эвдрэх		x		x					x			
Ахуйн бохир ус, нефтийн бүтээгдэхүүн хөрсөнд нэвчиж, хөрс, хөрсний усыг бохирдуулах			x	x					x			

Ахуйн бохир усны цооног, бие засах газар, хогийн цэгийн ариутгал муугаас эвгүй үнэр гарах, ялаа батгана, үржих	x		x			x		x		
Хүчтэй салхи шуурга, үер, гал түймэр, газар хөдлөл, аянга зэргээс үүдэн гарах аюул осол	x		x			x				x
Дуу шуугианы нөлөөлөл	x		x			x			x	
Дүн	x-10 +4	x-10	x-19 +4	x-1	x-1	x-3	x-5	x-9	x-10	x-2 +4

Тайлбар: (x) сөрөг нөлөөлөл; (+) эерэг нөлөөлөл.

Шууд нөлөөлөл

Төслийн нөлөөллийг тогтооход үйл ажиллагаанаас үүдэн гарч болзошгүй шууд нөлөөллийн тоо 14 байна. Эдгээр нөлөөлөлд газрын доорх усны нөөц горимын өөрчлөлт, ургамлан нөмрөгийн өөрчлөлт, хөрсний элэгдэл, эвдрэл, ахуйн зориултаар ашиглах усны нөөц, агаарын бохирдол, хөрсний бохирдол, зам харилцаа, машин механизмын хөдөлгөөнөөс хөрс эвдрэх, ахуйн бохир усны цооног, бие засах газар, хогийн цэгийн ариутгал муугаас эвгүй үнэр гарах, ялаа батгана үржих, хүчтэй салхи, шуурга, гал түймэр, газар хөдлөл, аянга цахилгаан зэргээс үүдэн гарах осол аюул, дуу шуугианы нөлөөллийг хамааруулан авч үзэв.

Шууд бус нөлөөлөл

Энд 10 төрлийн нөлөөлөл багтаж байна. Гадаргын усны нөөц, горимын өөрчлөлт, хөрсний үржил шим, газрын доорх усны чанарын өөрчлөлт, гадаргын усны чанарын өөрчлөлт, ургамлан нөмрөгийн бохирдол, байгалийн унаган төрх өөрчлөгдөх, ландшафтын хэлбэр, дүрс, өнгө төрх өөрчлөгдөх, тусгай хамгаалалттай газар нутагт нөлөөлөх нөлөөлөл, ажиллагсдын эрүүл мэндэд нөлөөлөх нөлөөлөл, ахуйн бохир ус, нефтийн бүтээгдэхүүн хөрсөнд нэвчиж, хөрс, хөрсний усыг бохирдуулах зэрэг нөлөөллүүдийг хамааруулан авч үзэв.

Болзошгүй нөлөөллийн үргэлжлэх хугацаа

Төслийн нөлөөллийг үргэлжлэх хугацааных нь хувьд богино хугацааны нөлөөлөл 23, дунд хугацааны нөлөөлөл 1, урт хугацааны нөлөөлөл 1 байна.

Богино хугацааны нөлөөлөлд: Газрын доорх усны нөөц, горимын өөрчлөлт, гадаргын усны нөөц, горимын өөрчлөлт, ургамлан нөмрөгийн өөрчлөлт, хөрсний элэгдэл, эвдрэл, зэрлэг ан амьтдын байршилт, тархалтын өөрчлөлт, ахуйн зориулалтаар ашиглах усны нөөц, гадаргын усны чанарын өөрчлөлт, агаарын бохирдол, хөрсний бохирдол, ургамлан нөмрөгийн бохирдол, байгалийн унаган төрх өөрчлөгдөх, ландшафтын хэлбэр дүрс, өнгө төрх өөрчлөгдөх, тусгай хамгаалалттай газар нутагт нөлөөлөх нөлөөлөл, ажиллагсдын эрүүл мэндэд нөлөөлөх нөлөөлөл, зам харилцаа, машин механизмын хөдөлгөөнөөс хөрс эвдрэх, ахуйн бохир ус, нефтийн бүтээгдэхүүн хөрсөнд нэвчиж хөрс, хөрсний усыг бохирдуулах, хүчтэй салхи, шуурга, үер, гал түймэр, газар хөдлөл, аянга зэргээс үүдэн гарах аюул осол, дуу шуугианы нөлөөллийг хамааруулан авч үзэв.

Мөн улс, орон нутгийн төсвийн орлого нэмэгдэх, орон нутагт ядуурлыг бууруулахад дэмжлэг үзүүлэх, шинээр ажлын байр нэмэгдэх зэрэг нь богино хугацааны эерэг үр дагавартай байна.

Дунд хугацааны нөлөөлөлд: Хөрсний үржил шимд үзүүлэх сөрөг нөлөөллийг хамааруулан авч үзэв.

Урт хугацааны нөлөөлөлд: Газрын доорхи усны чанарын өөрчлөлтийг хамааруулан авч үзэв.

Нөлөөллийн буцах болон эргэлт буцалтгүй байдал

Буцаж нөлөөлөх нөлөөлөлд ахуйн бохир усны цооног, бие засах газар, хогийн цэгийн ариутгал муугаас эвгүй үнэр гарах, ялаа батгана үржих, гэх мэт нөлөөллүүд хамаарна.

Эргэж буцалтгүй нөлөөлөх нөлөөлөлд газрын доорхи усны нөөц, горимын өөрчлөлт, гадаргын усны нөөц горимын өөрчлөлт, ургамлан нөмрөгийн өөрчлөлт, зэрлэг ан амьтдын байршилт, тархалтын өөрчлөлт, хөрсний үржил шимд нөлөөлөх нөлөөллүүдийг хамааруулан авч үзэв.

Нөлөөллийн эрчимшил

Төслийн нөлөөллийг эрчимшлийн хувьд авч үзвэл нийт нөлөөлөлд хүчтэй нөлөөлөл байхгүй, сулавтар эрчмийн нөлөөлөл 9, бага эрчмийн нөлөөлөл 10, дунд, 6 эрчимшилтэй байна.

Сулавтар эрчимшилтэй нөлөөлөлд гадаргын усны нөөц, горимын өөрчлөлт, гадаргын усны чанарын өөрчлөлт, ургамлан нөмрөгийн бохирдол, байгалийн унаган төрх өөрчлөгдөх, ландшафтын хэлбэр дүрс, өнгө төрх өөрчлөгдөх, тусгай хамгаалалттай газар нутагт нөлөөлөх нөлөөлөл, зам харилцаа, машин механизмын хөдөлгөөнөөс хөрс эвдрэх, ахуйн бохир ус, нефтийн бүтээгдэхүүн хөрсөнд нэвчиж, хөрс хөрсний усыг бохирдуулах, ахуйн бохир усны цооног, бие засах газар, хогийн цэгийн ариутгал муугаас эвгүй үнэр гарах, ялаа батгана үржих зэрэг нөлөөллүүдийг хамааруулан авч үзэв.

Бага эрчимшилтэй нөлөөлөлд газрын доорхи усны нөөц, горимын өөрчлөлт, ургамлан нөмрөгийн өөрчлөлт, хөрсний элэгдэл, эвдрэл, зэрлэг ан амьтдын байршилт, тархалтын өөрчлөлт, хөрсний үржил шим, газрын доорхи усны чанарын өөрчлөлт, агаарын бохирдол, хөрсний бохирдол, ажиллагсдын эрүүл мэндэд нөлөөлөх нөлөөлөл, дуу шуугианы нөлөөлөл зэргийг хамааруулан авч үзэв.

Дунд эрчмийн нөлөөлөлд ахуйн зориулалтаар ашиглах усны нөөц, хүчтэй салхи, шуурга, үер, гал түймэр, газар хөдлөлт, аянга зэргээс үүдэн гарах осол аюул зэргийн хамааруулан авч үзэв.

3.3.Төслийн байршил, шийдэл, төлөвлөлтөөс үүсэх нөлөөлөл

Хайгуулын ажил явагдах талбай нь Өвөрхангай аймгийн Баруунбаян-Улаан, Гучин-Ус сумын нутаг дэвсгэрт байрлах бөгөөд Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний ажлын судалгаагаар төсөл хэрэгжих газарт малчин айл өрхүүд, өвөлжөө, хаваржаа, түүх соёлын өв илрээгүй тул ямар нэгэн объектыг нүүлгэн шилжүүлэх асуудал гарахгүй юм.

ДӨРӨВ. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Зорилго, зорилт: Газрын тосны хайгуулын Онги V талбайн 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний үндсэн зорилго нь 2021 онд батлагдсан “Эко Натур” ХХК-ийн боловсруулсан Өвөрхангай аймгийн Баруунбаян-Улаан сумын 3-р багийн нутаг дэвсгэрт хайгуулын 2 цооног өрөмдөх төслийн Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ, 2022 онд батлагдсан Онги-V талбайд 3 хэмжээст чичирхийллийн судалгааны ажлын Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний тодотгол тайлангуудын хүрээнд тогтоогдсон төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээг хэрэгжүүлэн төлөвлөсөн ажлын хэрэгжилтийг хангаж ажиллах үндсэн зорилготой.

Хамрах хүрээ: Газрын тосны хайгуулын Онги-V талбайн БОННУ-г холбогдох хууль, журмын дагуу БОАЖЯ-аар батлуулсан. 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд 3 хэмжээст чичирхийллийн судалгаа хийх, хайгуулын тулгуур 2 цооног өрөмдлөг, цооногийн туршилт, шингэн хагалбарын ажлын үед хэрэгжүүлэх байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрүүд болно.

Газрын тосны хайгуул судалгаа хийх “Онги-V” талбайн Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг нь “Байгаль орчныг хамгаалах тухай”, “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” хуулиуд, Монгол улсын Засгийн газрын 2013 оны 374 дүгээр тогтоолоор баталсан “Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний журам”, БОАЖЯ-ны сайдын 2019 оны 10-р сарын 29-ний өдрийн А-618 журмын 3 дугаар хавсралтаар баталсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-уудыг тус тус баримталснаас гадна байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний үр дүнд тулгуурласан болно.

МУ-ын ерөнхийлөгчийн санаачлагаар хэрэгжүүлж буй “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд Газрын тосны хайгуулын Бүтээгдэхүүн хуваах гэрээ /БХГ/-т Онги V Талбайд хамаарах Өвөрхангай аймгийн Гучин-Ус суманд тус сумын Засаг даргын 2022/09/02 ны өдрийн 1/73 тоот албан хүсэлтээр суманд “Тэр бум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд 2500 модны суулгац тариалах зардал болох 10.000.000 төгрөгний хүсэлтийг үндэслэн манай компани санхүүжилтыг шийдвэрлэж өгсөн.

Өвөрхангай аймгийн Баруунбаян-Улаан сумын Засаг даргын 2022/05/27 ны өдрийн 3/109 тоот албан хүсэлтээр суманд “Тэр бум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд суманд тариалж байгаа мод суулгацыг услах зориулалт бүхий мод усалгааны худгийн цооног өрөмдөх зардалд 13.000.000 төгрөг шийдвэрлэж өгсөн.

4.1. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 4. 1. Агаарын чанарт нөлөөлөх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал (мян.төг)	Тоо хэмжээ	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Биелэлтийн шалгуур	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8		9
	Авто тээврийн хэрэгслийн хөдөлгөөн, төслийн эхний үе шатан дахь бүтээн байгуулалт, өрөмдлөгийн тоног төхөөрөмжийн суурилуулалт, өрөмдлөгийн үйл ажиллагаанаас агаар орчинд тоосжилт үүсэх	Тээврийн хэрэгсэл зорчих нэгдсэн маршрут буюу НЭГ ЗАМЫН БОДЛОГО баримтлах, чанд мөрдүүлэх, тэмдэглэгээ байршуулах	Төслийн талбайд	Ширхэг	300,0	5	1,500.0	2023 онд	Батлагдсан маршрутаар явж байгаад тавьсан хяналт	*МУ -ын агаарын тухай хууль /2012.5.27/, Агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль /2010.6.24/
		Хурдны хязгаарлалтын тэмдэглэгээ	Төслийн талбайд	Ширхэг	250,0	10	2,500.0	2023 онд	Замын тэмдэгүүд байршуулсан эсэх	*Агаарын чанар. Техникийн шаардлага MNS 4585:2016,
		Цаг агаар, уур амьсгал, хуурайшилтын нөхцөл байдалтай уялдуулж зам талбайн усалгааг хийж тоосжилт үүсэхийг хязгаарлах	Төслийн талбайд ажиллах тээврийн хэрэгслүүд	Хуваарьт үзлэг, оношлогоо	Үйл ажиллагааны зардалд тусгагдсан		2023 онд	Зам талбайн усалгаа хийсэн байдал	*Агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэм хэмжээ. Техникийн ерөнхий шаардлага MNS 5885:2008,	
		Агаарын чанарын хяналт шинжилгээ хийж, үр дүнг	Төслийн талбай дахь хяналтын цэгт	Хяналт шинжилгээ хийсэн тоо		3 удаа	ОХШХ-т тусгагдсан	2023 онд		

		нэгтгэн тайлагнах							Орчны хяналт шинжилгээний ажлын тайлан	*Хүрээлэн буй орчны агаарын чанарын хяналтын төлөвлөгөө MNS ISO 4227:2002
Нийт зардал							4,000.0			

Хүснэгт 4. 2. Гадаргын ба газрын доорхи усны нөөцөд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал (мян.төг)	Тоо хэмжээ	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Биелэлтийн шалгуур	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	2	3	4	5	6	7	8	9	10	
ГАДАРГЫН БА ГАЗРЫН ДООРХИ УСНЫ НӨӨЦ	Орчны болон төсөл хэрэгжих орчны гадаргын болон газрын доорхи усны нөөцөд сөргөөр нөлөөлөх, бохирдуулах	Ус ашиглуулах дүгнэлт гаргуулан, сумын засаг даргатай ус ашиглах гэрээ байгуулан ажиллах.	Төслийн кемпийн талбайд	--*--				2023 онд	Гэрээ байгуулж ус ашиглах зөвшөөрөл авсан эсэх	*МУ -ын Усны тухай хууль /2012.5.17/ *Ус бохирдуулсны төлбөрийн тухай хууль /2012.5.17/ *Байгаль орчныг хамгаалах. Усан орчин, гадаргын усны чанарыг хянах
		Хөрсөнд ямар нэгэн хаягдал бохир шингэн зүйлс /угаадас, шатах тослох материал, түлш г.м/ ил задгай хаяхгүй байх тал	Төслийн кемпийн талбайд	Бохир зөөвөрлөлт ийн тоо бүртгэл	--*--			2000,0	2023 онд	

		дээр хяналт тавьж ажиллах								журам MNS 4047:1988,
		Усан орчны чанарын хяналт шинжилгээ хийж, үр дүнг нэгтгэн тайлагнах	Төслийн ойр орчны уст цэгүүд, ашиглаж буй худаг	Хяналтын тоо	--*--	3 удаа	ОХШХ-т тусгагдсан	2023 онд	Орчны хяналт шинжилгээн ий тайлан	*Усны биологийн шинж чанарын шинжилгээ. Бохир усны микробиологи йн шинжилгээний арга MNS 5668: 2006, *Усан орчны чанарын үзүүлэлт. Ерөнхий шаардлага MNS 4586:1998, *Усны чанар. Газрын доорх усыг бохирдуулагч бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ MNS 6148:2010 *Ундны усны стандарт MNS 900-2005

										Усны нөөцийг бохирдлоос хамгаалах дүрэм 143/а/352	
			Нийт зардал				2000,0				

Хүснэгт 4.3. Хөрсөн бүрхэвчид үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал (мян.төг)	Тоо хэмжээ	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Биелэлтийн шалгуур	Баримтлах эрх зүйн баримт бичиг	
	1	2	3	4	5	6	7	8	9	10	
ХӨРСӨН БҮРХЭВЧ	Өрөмдлөгийн ажил, өрмийн тоног төхөөрөмжийн суурилуулалт, кемпийн талбай дахь өдөр тутмын хөдөлгөөнд хөрсний эвдрэл элэгдэл үүсэх, ахуйн хатуу болон шингэн хог хаягдлаар хөрсөнд бохирдол үүсэх	Ил задгай ахуйн хог хаягдал хаяхаас сэргийлэн кемпэд хогийн сав байршуулах	Төслийн кемпийн талбай дотор	ш	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан			2023 онд	Хогийн сав байршуулсан эсэх	Газрын тос, байгалийн хий үйлдвэрлэгчдийн олон улсын холбооны стандарт – IOGP standard MNS5850-2008, “Хөрсний чанар, хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ”	
		Өрөмдлөг, хаягдлын сан байгуулах талбайн шимт хөрсийг тусад нь авч хадгалан цооног хаах битүүмжлэх, хаягдлын сангийн нөхөн сэргээлтэд дахин ашиглах зориулалтаар шимт хөрсний овоолго хийнэ	Шимт хөрсний овоолгод	М.кв	Үйл ажиллагааны зардалд тусгагдсан				2023 онд	Шимт хөрсний овоолго, нөхөн сэргээлтэд ашигласан байдал	MNS5914-2008, “Эвдэрсэн газрын нөхөн сэргээлтийн нэр томъёо, тодорхойлолт” MNS5916-2008, “Байгаль орчин. Газар шорооны ажлын үеийн үржил шимт хөрс хуулалт, хадгалалт”
		НИЙТ ЗАРДАЛ						2,500.0			

Хүснэгт 4. 4. Ургамлан нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал (мян.төг)	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Нийт зардал, мян.төг	Хариуцах тал	Биелэлтийн шалгуур	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	2	3	4	5	6	7	8	9	10	
УРГАМЛАН НӨМРӨГ	Газар хөндөх талбай, машин техник, орчны бохирдлоос үүдэн ургамлан нөмрөг устгах, биомасс багасах.	Эвдэгдсэн талбайд нөхөн сэргээлтийн ажлыг ерөмдлөгийн ажил дууссаны дараа хугацаа алдалгүй хийж гүйцэтгэх	Төслийн талбайд	Нөхөн сэргээлт хийгдсэн байдал	--*--	2023 онд	Үйл ажиллагааны зардалд тусгагдсан	Капкорп Монголиа ХХК ХАБЭА-БО-ны хэлтэс, туслан гүйцэтгэгч	Нөхөн сэргээлт хийгдсэн байдал,	*Байгалийн ургамлын тухай хууль /1995.4.11/ *Эвдэрсэн газрыг ургамалжуулах техникийн шаардлага MNS 5918:2008
		Ургамлан бүрхэвчийн мониторингийн судалгаа хийх	Төслийн талбайд	Судалгаа хийх давтамж	--*--	2023 онд 2 удаа	ОХШХ-т тусгагдсан	Капкорп Монголиа ХХК ХАБЭА-БО-ны хэлтэс, туслан гүйцэтгэгч	Орчны хяналт шинжилгээний ажлын тайлан	
Нийт зардал							--*--			

Хүснэгт 4. 5. Амьтны аймагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж, тоо хэмжээ	Нэгжийн зардал (мян.төг)	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Нийт зардал, мян.төг	Хариуцах тал	Биелэлтийн шалгуур	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8	9	10
АМЬТНЫ АЙМАГ	Дуу чимээ, техник хэрэгслийн хөдөлгөөн зэргээс үүдэн амьтад дайчих, амьдрах тархац нутгийн байршил, нүүдлийн зам зэрэг нь түр хугацаанд өөрчлөгдөх	Төсөл хэрэгжих талбайн ан амьтдын талаар мэдээлэл судалгааг орчны хяналт шинжилгээний ажлын хүрээнд хийх	Төслийн талбайд	1 удаа	-	2023 онд	2,500.0	Капкорп Монголиа ХХК, ХАБЭА-БО-ны хэлтэс, гэрээлэгч байгууллага	Орчны хяналт шинжилгээний тайлан	*Амьтны тухай хууль *Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенци
			Нийт зардал				4,500.0			
	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний нийт зардал						13,000.0			

4.2. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 4. 6. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө

№	Нөхөн сэргээлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Цар хүрээ	Хэмжээ, га	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэгч, хамтран хэрэгжүүлэгч	Биелэлтийн шалгуур	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	2	3	4	5	6	7	8	
1.	<p>Техникийн нөхөн сэргээлт:</p> <p>Нөхөн сэргээлтийн техникийн үе шатанд хөндсөн талбайг эргүүлэн дүүргэх, булж, тэгшлэх, хэлбэршүүлэх замаар хүн, мал, амьтанд аюулгүй болгоно.</p>	<p>Өрөмдлөгийн талбайн нөхөн сэргээлт:</p> <p>Үүнд: өрөмдлөгийн шингэн хаягдлын сан, ахуйн шингэн хаягдлын нүх, тоног төхөөрөмж байрласан талбай, үйл ажиллагааны улмаас талхлагдсан талбай г.м</p> <p>Жич: өрөмдлөгийн талбайн техникийн нөхөн сэргээлтийн ажлыг тухайн цооногт хийгдэх бүх туршилт, судалгаа, шингэн хагалбарын ажлууд хийгдэж дууссаны дараа гүйцэтгэнэ.</p>	Хайгуулын-2 цооногуудыг өрөмдөх талбай,	1 цооног өрөмдлөгийн талбай: 3 га	Гэрээт байгууллагаар гүйцэтгүүлэх нөхөн сэргээлтийн зардал 24,112.0	Капкорп Монголиа ХХК ХАБЭА, БО-ны хэлтэс Өрөмдлөгийн гэрээт байгууллага Нөхөн сэргээлтийн гэрээт байгууллага АМГТГ Сум орон нутгийн иргэд, аймаг сумын ЗДТГ	2018.02.22 -ны хамтарсан тушаал А-50/А-31-д заасны дагуу нөхөн сэргээлтийг актаар хүлээлцсэн байдал	<p>*Уул уурхайн үйл ажиллагаанаас эвдрэлд орсон газарт техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийх аргачлал. <i>Байгаль Орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайдын 2015 оны А-138 дугаар тушаалын хавсралт</i></p> <p>*Газрын тосны хайгуул, олборлолтын үйл ажиллагааны үеийн байгаль хамгаалал, нөхөн сэргээлт. <i>Техникийн шаардлага MNS 6200:2010</i></p> <p>*Эвдэрсэн газрыг ургамалжуулах техникийн шаардлага MNS 5918:2008</p> <p>*Газар шорооны ажлын үед үржил шимт хөрс хуулалт, хадгалалт MNS 5916:2008</p> <p>*Хөрсний чанар. Хөрс бохирдуулагч бодис,</p>

2.	Биологийн нөхөн сэргээлт	<p>Өрөмдлөгийн талбайн биологийн нөхөн сэргээлт:</p> <p>Үүнд: өрөмдлөгийн шингэн хаягдлын сан, ахуйн шингэн хаягдлын нүх, тоног төхөөрөмж байрласан талбай, үйл ажиллагааны улмаас талхлагдсан талбай г.м</p> <p>Ургамал ургалтын улирлыг харгалзан үзэж мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлнэ.</p> <p>Жич: өрөмдлөгийн талбайн биологийн нөхөн сэргээлтийн ажлыг тухайн цооногт хийгдэх бүх туршилт, судалгаа, шингэн хагалбарын ажлууд хийгдэж дуусаад техникийн нөхөн сэргээлт хийгдсэний дараа ургамал ургалтыг улирлыг харгалзан тохиромжтой улиралд нь хийж гүйцэтгэнэ.</p>	<p>Хайгуулын-2 цооногуудыг өрөмдөх талбай,</p> <p>3 хэмжээст чичирхийллийн судалгаа хийгдсэн тохиолдол кемп байрласан талбай</p>	<p>1 цооног өрөмдлөгийн талбай: 3 га</p>	<p>Гэрээг байгууллагаар гүйцэтгүүлэх нөхөн сэргээлтийн зардал</p> <p>50,380.0</p>		<p>элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ MNS 5850:2008</p> <p>*Газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуул, олборлолтын үйл ажиллагаанд өртсөн байгаль орчныг нөхөн сэргээх ажлыг хүлээн авах журам 2018.02.22 -ны хамтарсан тушаал А-50/А-31</p>
		Нийт зардал			74,492.0		

4.3. ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 4. 7. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

Хийх ажил	Хариуцах ААН	Баримтлах эрх зүйн орчин, шаардлага
Газрын тосны хайгуул судалгааны ажил	Капкорп Монголиа ХХК	Хайгуулын ажил дуусч олборлолтын шатанд шилжих үеэс дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөг мэргэжлийн байгууллагын оролцоотойгоор орон нутаг, байгаль орчны хяналтын улсын байцаагчидтай зөвлөлдөн боловсруулж хэрэгжүүлнэ.

4.4. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Нүүлгэн шилжүүлэлт болон нөхөн олговор олгох шаардлагагүй. Манай компани өрмийн гэрээт гүйцэтгэгч компанитай ажил эхлэх үед “Яаралтай үед авах хариу арга хэмжээний төлөвлөгөө”-г хэрэгжүүлэн ажиллах шаардлагыг гэрээний хүрээнд тусган хамтран ажиллана.

4.5. ТҮҮХ СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Биет болон биет бус соёлын өвийг хамгаалах ЮНЕСКО-ийн конвенци, Монгол Улсын Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн дагуу “Төслийн явцад түүх, соёлын дурсгалт зүйл болон археологи, угсаатан, палеонтологийн олдвор илэрвэл хайгуулын үйл ажиллагааг зогсоож харьяа сум, аймгийн засаг дарга, цагдаагийн байгууллагад болон холбогдох эрдэм шинжилгээний байгууллагад нэн даруй мэдэгдэнэ” гэж дурьдсаныг мөрдлөг болгон түүх соёл, байгалийн дурсгалт газрууд, түүхийн дурсгалыг хадгалан үлдээх, хамгаалах зорилго тавин үйл ажиллагаагаа явуулна.

4.6. ОСОЛ ЭРСДЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 4. 8. Осол эрсдлийн менежментийн төлөвлөгөө

№	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, мян.төг	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Шалгуур үзүүлэлт	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8	9
1.	Байгалийн гаралтай осол, эрсдэл	Орон нутгийн иргэд болон талбай дээр ажиллаж буй ажиллагсад тухайн бүс нутагт тохиолддог байгалийн гаралтай осол үүсэх нөхцөл байдлын талаарх мэдээлэл өгөх, энэ үед хувь хүн болон хээрийн ажлын үед авах арга хэмжээний талаарх зөвлөмж өгөх	Бүс нутагт	1	1,000.0	1,000.0	2023 он	Ажилчдад, орон нутгийн иргэдэд өгсөн мэдээлэл сургалт зэргээс	“Аюултай ачаа бараа тээвэрлэх зөвлөмж, зохицуулалтын заавар” - Монгол Улсын замын хөдөлгөөний дүрэм - MNS 4978:2000 Аюултай ачаа,

		Гал унтраах иж бүрэн хэрэгсэл	Төслийн талбайд	1	Үйл ажиллагааны зардалд тусгагдсан		2023 онд	Гал унтраах хэрэгсэл байрлуулсан эсэх	ангилал, техникийн шаардлага
2.	Биологийн гаралтай осол эрсдэл	Төсөл хэрэгжих явцад тухайн бүс нутаг болон ОУ, Монгол улсыг хамарсан өвчлөл гарч байгаа эсэхэд байнга анхаарч, гарсан тохиолдолд урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах	Төслийн талбай болон бүс нутаг	1	3,000.0	3,000.0	2023 онд	Авч хэрэгжүүлсэн арга хэмжээ	- БОАЖЯ-ын Сайд, ЭМ-ийн Сайд, ОБЕГ-ын Даргын 2009 оны 02 сарын 03-ны өдрийн 28/40/29 тоот хамтарсан тушаалаар баталсан "Химийн хорт болон аюултай бодисыг хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах журам" - MNS 5029:2011 Химийн хорт бодисын шошго тэмдэглэгээ - MNS6458:2014 Химийн хорт болон аюултай бодис, бүтээгдэхүүний агуулахад тавих шаардлага -MNS (ISO) 13688:2000 Хамгаалалтын хувцасны ерөнхий шаардлага
3.	Технологийн гаралтай осол эрсдэл	Ажиллагсдыг хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгслээр бүрэн ханган ажиллуулах	Ажилчид	Талбайд ажиллах компаний үндсэн ажилчид	Төсөвт зардалд тусгагдсан		Тогтмол	Ажилчид хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгслээр хангагдсан эсэх, хувийн хамгаалах хэрэгслийг ажилчдад олгосон бүртгэл	
		Хөдөлмөр хамгаалал болон болзошгүй осол, аюулаас урьдчилан сэргийлэх, осол аваарын үед авах арга хэмжээний төлөвлөгөө гарган цаг үеийн байдалтай уялдуулан тодотгол хийж, ажиллагсдад энэ үед хэрхэн ажиллах талаар мэдээлэл сургалт хийх	Сургалтын тоо	2	Үйл ажиллагааны зардалд тусгагдсан		2023 онд	Яаралтай үед авах хариу арга хэмжээний төлөвлөгөө, гамшгаас хамгаалах төлөвлөгөөний хэрэгжилт, ажилчдад хэрхэн ажиллах талаарх мэдээлэл, зааварчилгаа өгсөн эсэх	Гамшгаас хамгаалах тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн тухай хууль
Нийт					4,000.0				

4.7. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 4. 9. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, мян.төг	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа	Биелэлтийн шалгуур	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	2	3	4	5	6	7	8	9	10	
1.	Ахуйн шингэн хаягдал	Шингэн хаягдал, ариун цэврийн байгууламж /септик танк байршуулах/, эсвэл ахуйн шингэн хаягдлын танк суурилуулна	Өрөмдлөг, сейсмийн ажил явагдах кемпийн талбайд	ш	--*--	1	Гэрээт хайгуул судалгааны ажлын зардалд тусгагдсан	2023 онд	Шингэн хаягдлыг танк суурилуулан ахуйн шингэн хаягдлыг хадгалж зайлуулсан эсэх	*МУ-ын Хог хаягдлын тухай хууль, 2017.5.17 *МУ -ын Эрүүл ахуйн тухай хууль, 2016.2.29 *Энгийн хог хаягдлын норматив хэмжээг тогтоох аргачлал 2017.12.25. А-368 *Эх үүсвэрээс гарах хог хаягдлын кодчилсон жагсаалт, тэдгээрийн зэрэглэл 2017.12.12. А-349 *Байгаль орчин. газрын тос боловсруулах үйлд

